



НҮБ-ЫН ХҮНИЙ  
ЭРХИЙН ДЭЭД  
КОМИССАРЫН ГАЗАР

**ШААРДЛАГАД НИЙЦСЭН  
ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХИЙН ТАЛААР  
ХҮНИЙ ЭРХИЙН КОНВЕНЦУУДЫН  
ХОРООНООС БАТЛАН ГАРГАСАН  
ЕРӨНХИЙ САНАЛ, ЗӨВЛӨМЖ,  
УДИРДАМЖИЙН ЭМХЭТГЭЛ**



**Х ү н и й   Э р х**



Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр “Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд Монголын Эмнести Интернэшнлийн “Төр үүргээ мэд, биелүүл” кампанит ажлын “Орон байртай байх эрх-Эрх зүйн хөтөч” төслөөс 1000 ширхэг хэвлүүлэв.

Энэ гарын авлагыг Монголын Эмнести Интернэшнлээс үнэгүй авч болно.

2019 он

**Утас/Факс:** 976-70004705, 70004708

**Цахим шуудан:** [mongolia.amnesty@gmail.com](mailto:mongolia.amnesty@gmail.com)

**Цахим хуудас:** [www.amnesty.mn](http://www.amnesty.mn)



Amnesty International Mongolia-Монголын  
Эмнести Интернэшнл



НҮБ-ын Хүний Эрхийн  
Дээд Комиссарын Газар

**ШААРДЛАГАД НИЙЦСЭН  
ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХИЙН ТАЛААР  
ХҮНИЙ ЭРХИЙН КОНВЕНЦУУДЫН  
ХОРООНООС БАТЛАН ГАРГАСАН ЕРӨНХИЙ  
САНАЛ, ЗӨВЛӨМЖ, УДИРДАМЖИЙН  
ЭМХЭТГЭЛ**



## **АГУУЛГА**

НҮБ-ын Эдийн засаг, Нийгэм, Соёлын эрхийн Хороо, Ерөнхий Зөвлөмж №4	5-16
НҮБ-ын Эдийн засаг, Нийгэм, Соёлын эрхийн Хороо, Ерөнхий Зөвлөмж №4	17-26
Хөгжилд суурилсан нүүлгэлт болон шилжилт хөдөлгөөний талаарх үндсэн зарчим, удирдамж	27-49
Хавсралт	50-55

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ДД (IDPs)	Дотоодын шилжин суурьшигч
ОУХБ (ILO)	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
ТББ (NGOs)	Төрийн бус байгууллага
ХЭҮБ (NHRI)	Хүний эрхийн үндэсний байгууллага
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
НҮБ-ын ХЭДКГ (OHCHR)	НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газар
НҮБ-Хабитат (UN-Habitat)	НҮБ-ын Хүн амын нутагшил, суурьшлын Хөтөлбөр
НҮБ-ын ОББЭХ (UNHRP)	НҮБ-ын Орон байртай байх эрхийн хөтөлбөр
ЮНИСЕФ (UNICEF)	НҮБ-ын Хүүхдийн сан
ХЭТТ	Хүний эрхийн түгээмэл тунхаглал
ИУТЭОУП	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт
ЭЗНСЭОУП	Эдийн засаг, нийгэм, соёлын тухай олон улсын Пакт

**Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн хорооны  
Ерөнхий Зөвлөмж №4**

**ШААРДЛАГАД НИЙЦСЭН ОРОН  
БАЙРТАЙ БАЙХ ЭРХ**

**(ЭЗНСЭОУП-ын 11 зүйл (1))**

1991 оны 12 дугаар сарын 13-ны өдөр  
Эдийн засаг, Нийгэм, Соёлын Эрхийн Хорооны  
6 дугаар хуралдаанаар батлав. (баримт бичиг E/1992/23)

## **Ерөнхий Зөвлөмж №4**

# **ШААРДЛАГАД НИЙЦСЭН ОРОН**

# **БАЙРТАЙ БАЙХ ЭРХ**

### **(ЭЗНСЭОУП-ын 11 зүйл (1))**

1. ЭЗНСЭОУП-ын 11.1 дүгээр зүйлийн дагуу оролцогч Улсууд "хүн бүр болон түүний гэр бүл хүрэлцэхүйц хоол хүнс, хувцас, гэр орон зэргийг оролцуулан, шаардлага хангасан түвшинд аж төрөх, амьдралын нөхцөлөө байнга сайжруулах эрхтэй" гэж хүлээн зөвшөөрсөн. Шаардлага хангасан түвшинд амьдрах эрхээс урган гарсан шаардлагад нийцсэн орон байртай байх эрх нь эдийн засаг, нийгэм соёлын бүхий л эрхээ эдлэх хамгийн чухал үндэс суурь нь юм.

2. Хүний эрхийн конвенцуудын хороо (цаашид Хороо гэх) энэхүү эрхтэй холбоотой асар их мэдээлэл цуглуулсан. 1979 оноос хойш Хороо болон түүний үе үеийн ажилтнууд шаардлагад нийцсэн орон байртай байх эрхтэй холбоотой 75 илтгэлийг хянаж үзсэн байна. Мөн өөрийн 3 болон 4 дүгээр хуралдааны (E/1989/22, 312-р догол мөрийг үз), (E/1990/23, догол мөр 281-285) ерөнхий хэлэлцүүлгийн нэг өдрийг энэ асуудалд зориулсан байна. Түүнээс гадна Хороо нь 1987 оны 12-р сарын 11-ний өдрийн Ерөнхий Ассамблейн 42/191-р тогтоолоор баталсан "2000 он хүртэл орон байрны талаар баримтлах Дэлхийн Стратеги", мөн орон гэргүй хүмүүсийг орон гэртэй болгох олон улсын жилийн (1987 он) хүрээнд цугларсан мэдээллийг нухацтай авч үзсэн.<sup>1</sup>

Түүнчлэн холбогдох тайлан, Хүний эрхийн Комисс, Цөөнхийг ялгаварлан гадуурхахаас сэргийлэх, хамгаалах Дэд Комиссын бусад баримт бичгүүдийг хянан үзсэн.<sup>2</sup>

<sup>1</sup> Ерөнхий Ассамблейн 43-р хуралдааны албан ёсны тэмдэглэл, нэмэлт (A/43/8/Add. 1).

<sup>2</sup> Хүний эрхийн Комиссын 1986 оны 36 болон 1987 оны 22-р тогтоолууд, Дэд Комиссын Тусгай илтгэгч ноён Данило Туркийн тайлангууд (E/CN.4/Sub.2/1990/19, догол мөр. 108-120; E/CN.4/Sub.2/1991/17, догол мөр 137-139), мөн Дэд Комиссын 1991 оны 26-р тогтоолыг үз.



3. Олон улсын төрөл бүрийн баримт бичгүүдэд шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн талаар туссан байдаг хэдий ч Пактын 11.1 дүгээр заалт нь холбогдох бусад заалтуудаас хамгийн иж бүрэн, хамгийн чухал заалт юм.<sup>3</sup>

4. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Арьс өнгөөр алагчлахын бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн 5 (с) (iii) дахь хэсэг, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн 27 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Нийгмийн хөгжил, дэвшлийн тухай Тунхагийн 10 дугаар зүйл, Хүн амын суурьшлын талаарх Ванкуверийн Тунхагийн 3 дугаар зүйл, Амьдрах орчны талаарх тайлан: НҮБ-ын Хүн амын суурьшлын талаарх Бага хурал, 1976 он, (НҮБ-ын хэвлэл, Борлуулах дугаар. E.76.IV.7 болон засвар, 1-р бүлэг), Хөгжих эрхийн Тунхагийн 8 дугаар зүйл, Ажилчдын орон байрны асуудлаар ОУХБ-аас өгсөн зөвлөмж, 1961 он (Дугаар 115)-ыг үзнэ үү.

Орон гэргүй байх, шаардлага хангаагүй орон гэрт амьдрах зэрэг томоохон бэрхшээлүүд нөөц болоод бусад төрлийн хомсдол ихтэй хөгжиж буй оронд голдуу тулгарч байгаа ч эдийн засгийн хувьд өндөр хөгжсөн орнуудад ч бас байсаар байна. НҮБ-ын тооцоолсноор дэлхий дээр 100 сая гаруй хүн орон гэргүй, 1 тэрбум гаруй хүн шаардлага хангаагүй орон байранд амьдарч байна.<sup>4</sup> Энэ тоо буурч байгааг харуулах ямар ч үзүүлэлт байхгүй байна. Орон байртай байх эрхийн хувьд ямар ч хүндрэл, асуудалгүй “Оролцогч улс орон” гэж байхгүй нь тодорхой.

5. Хорооноос хянан үзсэн оролцогч улсуудын тайланд шаардлагад нийцсэн орон байраар хангах эрхийг хэрэгжүүлэхэд учирч буй бэрхшээл, хүндрэлүүдийг тайлбарласан байдаг. Гэхдээ, энэ мэдээлэл

---

<sup>3</sup> Жишээ болгон, Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Арьс өнгөөр Алагчлахын Бүх хэлбэрийг Устгах тухай Конвенцийн 5 (с) (iii) дахь хэсэг, Эмэгтэйчүүдийг Алагчлах Бүх хэлбэрийг Устгах тухай Конвенцийн 14.2 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн 27 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Нийгмийн Хөгжил, Дэвшлийн тухай Тунхагийн 10 дугаар зүйл, Хүн амын суурьшлын талаарх Ванкуверийн Тунхагийн 3 дугаар зүйл, Амьдрах орчны талаарх тайлан: НҮБ-ын Хүн амын суурьшлын талаарх Бага хурал, 1976 он, (НҮБ-ын хэвлэл, Борлуулах дугаар. E.76.IV.7 болон засвар, 1 дүгээр бүлэг), Хөгжих Эрхийн Тунхагийн 8 дугаар зүйл болон Ажилчдын орон байрны асуудлаар ОУХБ-аас өгсөн зөвлөмж, 1961 он (Дугаар 115)-ыг үз.

<sup>4</sup> 1-р тэмдэглэлийг үзнэ үү.

улс орнуудад тулгараад байгаа нийтлэг асуудлын талаарх хангалттай дүр зургийг гаргаж чадахгүй байна. Энэхүү ерөнхий зөвлөмж нь Хорооноос уг эрхтэй холбогдуулан чухал гэж авч үзэж байгаа зарим үндсэн асуудлыг тодорхойлоход чиглэх болно.

6. Хүн бүр шаардлагад нийцсэн орон байртай байх эрхтэй. "Тэр эрэгтэй болон тэр эрэгтэйн гэр бүл" гэсэн тодорхойлолт нь Пакт батлагдсан 1966 оны үед түгээмэл байсан, эдийн засагт гүйцэтгэх жэндэрийн үүрэгтэй хамааралтай ойлголт учраас өнөөгийн нөхцөлд уг эрхийг хувь хүн, эсвэл эмэгтэй өрхийн тэргүүнтэй гэр бүл болон бусад бүлгийнхний эрхийг ямар нэг байдлаар хязгаарлаж болох мэтээр ойлгож болохгүй юм. Ийм учир "Гэр бүл" гэдгийг боломжит өргөн утгаар нь авч ойлгох хэрэгтэй. Түүнчлэн хувь хүн болон гэр бүлийн гишүүд нас, эдийн засгийн байдал гэх мэт өөр бусад ялгаатай байдлаасаа үл хамааран шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг эдлэх учиртай. Тодруулж хэлбэл энэхүү эрхийг хэрэгжүүлэхдээ Пактын 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу ямар нэгэн хэлбэрээр алагчлах явдал гаргахгүй байх ёстой.

7. Орон байртай байх эрхийг дөнгөж толгой хоргодох дээвэртэй л байвал орон гэртэй болчихлоо гэж үзэх, орон байрыг өргөн хэрэглээний бараа мэтээр тооцох, хязгаарлах буюу явцууруулан тайлбарлах ёсгүй гэж Хороо үздэг. Өөрөөр хэлбэл энэ эрх нь хүний аюулгүй, амар тайван, нэр төртэй амьдрах орчны тухай асуудал болохыг ойлгох ёстой. Энэ ойлголт нь дараах хоёр шалтгааныг агуулна. Нэгдүгээрт, орон байртай байх эрх нь хүний үндсэн болон бусад эрх, Пактад тусгагдсан суурь зарчмуудтай нягт холбоотой юм. Пактад тусгагдсан эрхүүдээс "хүний төрөлхийн нэр төртэй байх" гэдэг ойлголт нь "орон байр" гэдэг нэр томъёотой шууд хамааралтай бөгөөд холбогдох бусад асуудлын хамт анхаарч үзэх ёстой гэдэг байдлаар тайлбарлагдана. Хамгийн гол нь орон байртай байх эрх нь орлого, эдийн засгийн нөөцөөс хүртэх боломж зэргээс хамаарахгүйгээр бүх хүнд адил хэрэгжих ёстой. Хоёрдугаарт, 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь зөвхөн орон байрны тухай бус шаардлагад нийцсэн орон байрны тухай болохыг ойлгох ёстой юм. Хүн амын суурьшлын асуудал эрхэлсэн Хороо болон 2000 он хүртэл орон байрны талаар баримтлах Дэлхийн Стратегийн аль алинд зааснаар "Шаардлагад нийцсэн орон байр гэдэг нь ... хувь хүний эрх чөлөө, нууцлалын шаардлага хангасан, хүрэлцэхүйц зайтай, аюулгүй байдлыг бүрэн хангасан, гэрэлтүүлэг болон агааржуулалттай, шаардлага хангасан дэд бүтэцтэй, ажил

болоод бусад чухал байгууламжуудтай зохистой байршилтай, боломжийн үнэ өртөгтэй байх" тухай юм.

8. Тэгэхээр шаардлага хангасан гэдэг ойлголт нь орон байртай байх эрхийн чухал хэсэг болох ба ямар төрлийн орон байр нь Пактад тусгагдсан "шаардлагад нийцсэн орон байр"-тай нийцэж байгааг тодорхойлоход чиглэгдэж байна.

Шаардлага хангасан гэдэг ойлголт нь нийгэм, эдийн засаг, соёл, цаг уур, экологийн болон бусад хүчин зүйлүүдийн нэг хэсэг болохын хамт энэхүү эрхийн агуулгыг ямар ч нөхцөлд тодорхойлох боломжтой гэж Хороо үздэг. Үүнд:

*(а) **Эзэмшлийн аюулгүй байдал:** Эзэмшил нь байр түрээслэх (улсын болон хувийн), хоршооны байр лизингээр авах, өөрийн өмчийн байранд амьдрах, зээлээр түрээслэх, түр хугацаанд хоргодох байр, мөн газар болон өмчийн эзэмшил зэрэг албан бусаар суурьшин амьдрах олон хэлбэртэй байдаг. Эзэмшлийн ямар хэлбэртэй байгаагаас үл хамааран, бүх хүн хөөгдөх, дарамтлуулах, албадан нүүлгэх, болон бусад заналхийллээс хуулиар хамгаалагдсан аюулгүй орон байр эзэмших ёстой. Оролцогч улсууд ийм хамгаалалтаар дутагдаж байгаа, ийм нөлөөлөлд өртсөн хувь хүмүүс, бүлэгтэй зөвлөлдсөний үндсэн дээр эзэмшлийн эрх зүйн аюулгүй орчинг хуулийн дагуу хангахад чиглэсэн арга хэмжээг нэн даруй авах ёстой.*

*(б) **Үйлчилгээ, материал, байгууламж, дэд бүтцийн хүртээмж:** Шаардлагад нийцсэн орон байр нь эрүүл ахуй, аюулгүй байдал, тав тух, хоол хүнсний шаардлагыг хангах тухайлсан тоног төхөөрөмжийг багтаасан байх ёстой. Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхээ эдэлнэ гэдэг нь байгалийн болон ердийн эх үүсвэр, аюулгүй ундны ус, (цахилгаан) дулаан болон гэрэлтүүлэг, ариун цэврийн байгууламж, хүнсний агуулах, хог хаягдлын цэг болон цэвэр усны болон бохирын шугам, мөн онц байдлын үед үйлчилгээ авах байнгын боломжоор хангагдсан байх ёстой.*

*(г) **Худалдан авч болохуйц боломжийн үнэтэй байх:** Хувь хүний болон өрхийн орон байртай холбоотой санхүүгийн зардал нь бусад суурь хэрэгцээндээ аюул, эрсдэл учруулахгүй хэмжээнд байна. Орон байртай холбоотой зардлын эзлэх хувь өрхийн орлогын түвшинтэй нь нийцэж байх зохистой арга*

хэмжээг “Оролцогч улсууд” авах ёстой. “Оролцогч улсууд” орон байр авах бололцоогүй хүмүүст татаас олгохоос гадна орон сууц барихад шаардлагатай санхүүгийн бусад үйлчилгээг бүрдүүлэх ёстой. Хямд төсөр, боломжийн үнэтэй байх зарчмын дагуу түрээслэгчид түрээсийн шударга бус, хэт өндөр үнэ, түүний огцом өсөлтөөс хамгаалагдах ёстой. Барилгын материалын байгалийн нөөц нь хямд үнэтэй газарт улс орнууд энэхүү барилгын материалын олдоцыг хангаж өгөх ёстой.

(д) **Амьдрах орчин нөхцөл:** Шаардлага хангасан орон сууц нь хангалттай зай талбайтай, оршин суугчдыг халуун, хүйтэн, чийг, салхи болон эрүүл мэндэд нь хохирол учруулж болох бусад эрсдэл, барилгын хийцтэй холбоотой аюул осол болон өвчний халдвараас хамгаалсан, амьдран сууж болохуйц байх ёстой. Оршин суугчдын бие махбодын аюулгүй байдал мөн хамгаалагдах ёстой. Орон байрны асуудал нь халдварт өвчний тандан судлагаатай байнга холбогддог хүрээлэн буй орчны асуудал болохын хувьд Хорооны зүгээс Оролцогч улсуудыг ДЭМБ-аас баталж гаргасан орон сууцанд тавигдах Эрүүл ахуйн үндсэн зарчмуудыг иж бүрнээр нь хэрэгжүүлэхийг зөвлөдөг. Жишээлбэл: шаардлага хангаагүй, бүрэн бус орон байр болон ийм нөхцөлд амьдрах нь нас баралт, өвчлөлийн шалтгаан болж байдаг. /Женев. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, 1990 он./

(е) **Орон байрны хүртээмж:** Шаардлагад нийцсэн орон байр нь хүн бүрт хүртээмжтэй байх ёстой. Эмзэг бүлгийн хүмүүс шаардлагад нийцсэн орон байрны тогтвортой бөгөөд хүртээмжтэй нөөцөөр бүрэн хангагдсан байх ёстой. Энэхүү эмзэг бүлгийнхэнд өндөр настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй, эдгэшгүй өвчтэй, ДОХ-ын халдварт иргэд, эрүүл мэндийн хувьд байнга асуудалтай байдаг хүмүүс, сэтгэцийн өвчтэй, байгалийн гамшгийн хохирогчид, гамшигт өртөмтгий газар нутагт амьдардаг хүмүүс болон нэн тэргүүнд орон байраар хангавал зохих бусад бүлгийн хүмүүс орно. Орон байртай холбоотой хууль, бодлогууд нь эдгээр хүмүүсийн орон байрны онцгой хэрэгцээ шаардлага руу бүрэн чиглэгдсэн байх ёстой. Газар эзэмшээгүй, нийгмийн ядуу давхаргад хамрагддаг хүмүүст газар олгох явдлыг дэмжих нь ихэнх Оролцогч улсуудын баримтлах үндсэн бодлого байх ёстой. Газар олж авах эрхийг оролцуулаад, хүн бүр аюулгүй, тайван орчинд, нэр төртэй амьдрах эрхийг баталгаажуулахыг Засгийн газрууд тэргүүн зэргийн үүргээ болгон ажиллах ёстой.

(ё) **Байрлал:** Шаардлагад нийцсэн орон байр нь ажлын байр,

эрүүл мэндийн үйлчилгээ, сургууль, цэцэрлэг болон нийгмийн бусад үйлчилгээтэй ойр байна. Энэ шаардлага том хотууд, хөдөө орон нутгийн алинд ч ижил хэрэгжих ёстой. Мөн, орон байр нь оршин суугчдын эрүүл мэндэд аюул учруулахуйц бохирдсон газар, бохирдлын эх үүсвэртэй ойр баригдаж болохгүй.

(ж) **Соёлын онцлогт нийцсэн байх:** Орон байрыг барьж байгаа материал, барих арга хэлбэр, мөн эдгээрт баримтлаж байгаа бодлогууд нь соёлын ялгаатай, орон байрны олон янз байдлаа илэрхийлэх боломжийг хангах ёстой. Орон сууцны барилгад гарч байгаа орчин үеийн хөгжил, орон байрыг сайжруулах ажил нь соёлын ялгаа, онцлог байдлыг хадгалах болон орчин үеийн технологийн дэвшлийн аль алиныг нь харгалзсан байх ёстойг анхаарч үзвэл зохино.

9. Өмнө дурдсанчлан, шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг (хүний эрхийн хоёр Пакт) болон бусад хүчин төгөлдөр олон улсын гэрээ, конвенцид заагдсан эрхүүдээс салгангид авч үзэх боломжгүй. Үүнийг хүний нэр төртэй байх, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмуудтай холбож дээр авч үзсэн. Мөн, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх (оршин суугчид болон орон нутгийн бусад бүлгүүд гэх мэт), оршин суух газраа чөлөөтэй сонгох болон олон нийтийн шийдвэр гаргах үйл явцад оролцох гэх мэт бусад эрхийг бүрэн дүүрэн эдлэхэд шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг нийгмийн бүх бүлгүүд ойлгож, дэмжсэн байх явдал нэн чухал юм. Түүнээс гадна хүний хувийн болон, гэр бүл, орон байр, захидал харилцааны нууцад дур зоргоороо, хууль бусаар халдахгүй байх нь шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн салшгүй хэсэг.

10. Тухайн улс орнуудад хөгжлийн түвшингээс үл хамааран, зарим алхмуудыг нэн даруй авч хэрэгжүүлэх ёстой. Орон гэр, байртай болгох засгийн газрын авч хэрэгжүүлж ирсэн хэвшмэл арга барилаас татгалзаж, нөлөөлөлд орсон хүмүүсийг "өөрт нь туслуулах" чиглэлээр дэмжихийг Орон байрны талаар баримтлах Дэлхийн Стратеги болон олон улсын мэргэжилтэн, зөвлөхүүд зөвлөж байна. Тухайн арга хэмжээг Оролцогч улсын боломжит нөөц, чадвараас давсан гэж үзэж байвал Пактын 11.1, 22 болон 23 дугаар зүйлд зааснаар, олон улсын харилцааны журмын дагуу аль болох хурдан хугацаанд хүсэлт гаргаж, Хороонд мэдэгдэх нь зүйтэй.

11. Оролцогч улсууд тохиромжгүй нөхцөлд амьдарч байгаа нийгмийн бүлгүүдэд эхний ээлжинд анхаарал хандуулж, тодорхой арга хэмжээ авах ёстой. Бодлого, дүрэм журам нь давуу байдалтай нийгмийн бүлгүүдэд ашиг шим хүртээх зорилгоор батлагдах ёсгүй. Олон оролцогч улсуудын хувьд 1980-аад оны үед амьдрах орчин нь бүхэлдээ муудсан ба амьдрах нөхцөлөө байнга сайжруулах эрхэд гадны хүчин зүйлүүд нөлөөлж болзошгүй ч онцолж Хорооны Ерөнхий зөвлөмжид (2/1992/Е/1990/23, хавсралт III) дурдсанчлан гадны хүчин зүйл нөлөөлсөн хэдий ч Пактаар хүлээсэн үүрэг нь эдийн засгийн хямрал, бэрхшээлтэй үед ч тасралтгүй хэрэгжиж байх ёстой. Хорооны үзэж байгаагаар амьдралын болон орон байрны нөхцөл муудах, дордох явдал нь тухайн улсын бодлого, хууль тогтоомжийн шууд нөлөөлөл бөгөөд үүнийгээ засаж залруулах арга хэмжээ авахгүй байх нь Пактаар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байна гэсэн үг юм.

12. Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх асуудал нь Оролцогч улсуудад харилцан адилгүй байж болох хэдий ч Пакт нь гишүүн улс нэг бүрээс энэхүү зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай ямар нэгэн арга хэмжээ авахыг маш тодорхой шаарддаг. Тус Пакт нь оролцогч улсуудыг орон байрны талаар баримтлах Дэлхийн Стратегийн 32 дугаар хэсэгт заасны дагуу орон байрны үндэсний стратегийг батлан гаргахыг шаарддаг. Энэ нь "орон байрны нөхцөлийг сайжруулах зорилгуудыг тодорхойлох, зорилгоо биелүүлэхэд шаардлагатай боломжит нөөцийг эрэлхийлж, хамгийн үр ашигтай байдлаар шаардлагатай арга хэмжээг авахад зарцуулах цаг хугацаа, хариуцах эзнийг тодорхойлно гэсэн үг". Ач холбогдол, үр нөлөөг нь нэмэгдүүлэх, мөн хүний бусад эрхийг хүндэтгэн үзэх үүднээс дурдсан стратегийг боловсруулахдаа нөлөөлөлд өртсөн, орон гэргүй, шаардлага хангаагүй орон сууцад амьдарч байгаа хүмүүс болон тэдний төлөөллийг оролцуулж, өргөн хэмжээний хэлэлцүүлэг явуулан, саналыг тусгах нь зүйтэй юм. Цаашлаад Пактын 11 дүгээр зүйлээр хүлээсэн үүрэгтэй уялдуулах талаар (эдийн засаг, хөдөө аж ахуй, байгаль орчин, эрчим хүчний зэрэг) арга хэмжээ авах хэрэгтэй.

13. Орон байрны нөхцөл, байдлыг үр дүнтэй хянаж, шинжлэх явдал нь төрийн нэн даруй хэрэгжүүлэх үүрэг мөн. Оролцогч улсууд 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргийн дагуу өөрийн нутаг дэвсгэр дээр байгаа орон гэргүй, шаардлага хангаагүй орон байранд амьдарч байгаа хүмүүсийн талаарх асуудлыг бүрэн хэмжээнд тодорхойлохын тулд дангаараа эсвэл олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтрах, шаардлагатай ямар нэгэн арга хэмжээ авсан болохоо нотлон

харуулах ёстой. Үүнтэй холбогдуулан Хорооны зүгээс орон байрны хувьд тааруу болон эмзэг нөхцөлд байгаа нийгмийн бүлэг хүмүүсийн талаарх мэдээллийг бүрэн дүүрэн авах үүднээс илтгэлийн хэлбэр болон агуулгыг боловсруулах ерөнхий зааварчилгааг (Е/С.12/1991/1) дахин шинэчлэн гаргасан. Орон байрны хувьд тааруу болон эмзэг нөхцөлд байгаа нийгмийн бүлэг гэдэгт орон гэргүй хүн болон шаардлага хангаагүй орон байранд, мөн наад захын амьжиргааны эд зүйлгүй нөхцөлд "хууль бусаар" амьдарч байгаа, орон байрнаасаа хөөгдөж болзошгүй, албадан нүүлгэгдэх эрсдэлтэй болон бага орлоготой хүмүүсийг багтааж авч үздэг.

14. Оролцогч улс шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хангах үүргээ биелүүлэхийн тулд нийтийн болон хувийн хэвшилтэй хамтарсан, зохистой ямар ч арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж болно. Зарим Улсын хувьд төрийн санхүүжилтээр шинэ орон сууц барих нь ихээхэн үр ашигтай байсан ч, ихэнх тохиолдолд ийм орон сууцаар орон байрны хэрэгцээг Засгийн газрууд бүрэн шийдвэрлэх бололцоогүй болох нь харагддаг.

Оролцогч улсуудын зүгээс бололцоог олгох стратегийг шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хэрэгжүүлэх цогц үүрэг амлалтуудтай холбоотойгоор хөхүүлэн дэмжвэл зохино. Өөрөөр хэлбэл аль болох богино хугацаанд хүн бүрд энэ эрхийг эдлүүлэхийн тулд бололцоот эх үүсвэрийн хүрээнд шаардлагатай бүхий л арга хэмжээг цогцоор нь авсан гэдгийг харуулахад энэхүү үүргийн мөн чанар оршино.

15. Ихэнх ийм арга хэмжээ нь эх үүсвэрийг уг ажилд зарцуулах бодлогын хүрээнд санаачилга гаргахыг шаарддаг. Гэхдээ хууль эрх зүйн болон захиргааны арга хэмжээг дутуу үнэлж болохгүй. Орон байрны талаар баримтлах Дэлхийн Стратеги (6-67 дугаар хэсэг) энэ чиглэлд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төрлүүд болон ач холбогдолд анхаарлаа хандуулсан байдаг.

16. Зарим улсад шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулсан байдаг. Хороо ийм арга барилын хууль зүйн болон практик ач холбогдлыг онцгойлон сонирхож судалдаг. Тодорхой тохиолдлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, иймэрхүү хуулийн баталгаажуулалтыг хэрхэн хийх нь үр ашигтай байх талаар мэдээлж байх хэрэгтэй.

17. Хорооны зүгээс шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн бүрэлдэхүүн хэсгүүдийг наад зах нь дотоодын хууль тогтоомжид тусгагдсан хамгаалалттай нийцэж байгаа эсэхэд хяналт хийдэг. Эрх зүйн системээс хамаараад ийм хяналт нь дор дурдсан салбаруудыг хамарч болох ба үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- (а) төлөвлөсөн нүүлгэн шилжүүлэлт, эсвэл нураан сүйтгэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор шүүхэд гаргасан гомдол,
- (б) хууль бус нүүлгэн шилжүүлэлтийн дараа нөхөн төлбөр олгох арга зам эрэлхийлж байгаа эрх зүйн үйл явц,
- (в) байр болон газрын эздийн (нийтийн болон хувийн) түрээсийн төлбөрийн хэмжээ, орон сууцны засвар болон арьсны өнгө, эсвэл өөр бусад хэлбэрээр алагчилж үзсэн хууль бус үйлдэл, эсвэл тэдгээрийг дэмжсэн явдлын эсрэг гаргасан гомдол, нэхэмжлэл,
- (г) орон байрны хүртээмж болон байр хуваарилах үед гаргасан ялгаварлалтай холбоотой асуудлыг тайлбарласан мэдэгдэл,
- (д) байр болон газрын эздийн эсрэг гаргасан гомдол маргаан зэрэг багтана.

Зарим эрх зүйн системд их хэмжээгээр өсөн нэмэгдэж байгаа орон гэргүйдэлд тохирсон цогц арга хэмжээг авах боломжийг эрэлхийлэх нь зохистой.

18. Иймээс Хороо нүүлгэн шилжүүлэлтийг Пактад тусгагдсан шаардлагуудад нийцсэн тохиолдолд, зөвхөн онцгой нөхцөлд явуулж болно гэж үздэг.

19. Эцэст нь 11.1 дүгээр зүйлд Оролцогч улсууд "чөлөөт зохицолд үндэслэсэн олон улсын хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой" болохыг хүлээн зөвшөөрч байгааг мөн тэмдэглэсэн. Ерөнхийдөө, олон улсын хамтын ажиллагааны 5 хүрэхгүй хувь нь орон байр болон хүний суурьшилд зориулагддаг ба ийм санхүүжилтийг зарцуулахдаа эмзэг бүлгийхний асуудалд бага анхаарсан байна. Оролцогч улсын хүлээн авагч болон хангагч аль аль тал нь санхүүжилтийн үндсэн хэсэг нь олон хүнийг шаардлагад нийцсэн орон байртай болгоход зарцуулагдах явдлыг баталгаажуулах ёстой. Олон улсын санхүүгийн байгууллагууд барилгын бүтэц, хийц нь хүний шаардлагад нийцсэн орон байртай байх эрхээ эдлэхэд нь саад учруулахгүй байх арга хэмжээ авч хэрэгжүүлэх явдлыг дэмжинэ. Оролцогч улсууд олон



улсын санхүүгийн хамтын ажиллагааг төлөвлөхдөө шаардлагад нийцсэн орон байртай байх эрхтэй хамааралтай аль салбарт гадны санхүүжилтийг хамгийн үр дүнтэй ашиглах боломжтойг тодорхойлох хэрэгтэй.

Ийм шаардлагыг биелүүлэхдээ нөлөөлөлд өртсөн хүмүүсийн хэрэгцээ шаардлага, үзэл бодлыг бүрэн анхаарч үзэх ёстой.



**Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн хорооны  
Ерөнхий Зөвлөмж №7**

## **ШААРДЛАГАД НИЙЦСЭН ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХ**

**(ЭЗНСЭОУП-ын 11 зүйл (1)): Албадан нүүлгэлт**

(1997 оны 16-р хуралдаан)

## Ерөнхий Зөвлөмж №7

# ШААРДЛАГАД НИЙЦСЭН ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХ

(Пактын 11.1-р зүйл): Албадан нүүлгэлт

1. Хороо нь 1991 онд өгсөн Ерөнхий зөвлөмж №4-т, хүн бүр албадан нүүлгэлт, дарамт шахалт болон бусад аюул заналаас хуулиар хамгаалуулж, орон байрны эзэмшлийн аюулгүй байдлаар хангагдах ёстой гэж заасан байдаг. Хүчээр албадан нүүлгэх нь Пактын шаардлагад үл нийцнэ гэж Хороо тэмдэглэсэн байдаг. Оролцогч улсуудыг үүргээ биелүүлээгүй гэж дүгнэсэн тохиолдлыг оролцуулан, сүүлийн жилүүдэд хийгдсэн албадан нүүлгэн шилжүүлэлтийн тухай олон тайланг хүлээн авч танилцаад Хороо нь Пактад заасан үүрэг хариуцлагатай холбоотой хэргийг тодруулахаар ажиллаж байна.
2. Олон улсын хамтын нийгэмлэг албадан нүүлгэх нь ихээхэн ноцтой асуудал болохыг аль хэдийнээ хүлээн зөвшөөрсөн. 1976 онд НҮБ-ын Хүн амын суурьшлын асуудлын талаар Бага хурлаас "байгалийн нөөцийг хадгалж, хамгаалах болон эргэн суурьшуулах боломжгүй, нөхцөлд л өргөн хүрээний цэвэрлэгээ явуулахад" онцгой анхаарал хандуулах ёстойг тэмдэглэсэн байдаг. Ерөнхий Ассамблей 1988 онд 43/181-р тогтоолоороо баталсан, 2000 он хүртэл Орон байрны талаар баримтлах Дэлхийн Стратегид "[Засгийн газруудын] үндсэн үүрэг нь хүний орон байр болон түүний орчинд хохирол учруулж, сүйтгэх бус харин хамгаалж, сайжруулах явдал" гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Тогтвортой хөгжлийн стратеги (Agenda 21)-т "хүмүүс орон гэр, газраасаа шударга бусаар нүүлгэн шилжүүлэгдэхээс хуулиар хамгаалагдах ёстой" гэж тэмдэглэсэн байдаг.<sup>1</sup> "Хүний Амьдрах орчны талаарх стратеги"-д дурдсанаар, Засгийн газрууд "бүх хүнийг албадан нүүлгэлтээс хуулиар хамгаалах, хохирлыг нь барагдуулах, хүний эрхийн асуудалд анхаарлаа

<sup>1</sup> E/1998/22 тоот баримт болон, IV хавсралтанд бий. Хүн амын суурьшлын талаарх тайлан: НҮБ-ын Хүн амын суурьшлын асуудлаарх Бага хурал, Ванкувер, 1976 оны 5 сарын 31-6 сарын 11 өдөр (A/CONF.70/15), II бүлэг, зөвлөмж В.8, догол мөр С (ii). С (ii).

хандуулж, хэрвээ нүүлгэн шилжүүлэлтийг зайлшгүй явуулах болсон тохиолдолд зохистой хамгаалах хувилбаруудыг баталгаажуулж өгөх ёстой".<sup>2</sup> Хүний эрхийн хороо "албадан нүүлгэлт бол хүний эрхийн ноцтойг зөрчил" гэж дүгнэсэн байдаг. Эдгээр мэдэгдэл чухал боловч, ямар нөхцөлд нүүлгэн шилжүүлэлтийг хэрэгжүүлэх боломжтой гэж үзэх, Пактын холбогдох заалтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хамгаалалтын төрлүүдийг дэлгэрэнгүй тайлбарлах зэрэг хамгийн чухал асуудлуудыг тэдний зүгээс нээлттэй орхисон байдаг.<sup>3</sup>

3. "Албадан нүүлгэлт" гэдэг нэр томъёоны хэрэглээ заримдаа маргаантай байдаг. Энэ томъёолол нь дур зоргоороо болон хууль бус үйл ажиллагаа гэсэн ойлголтыг агуулдаг. Олон ажиглагчид "албадан нүүлгэлт" гэдгийг өөр үгээр тойруулан тайлбарлаж байна. Зарим нь амьдрал дээр "хууль бус нүүлгэн шилжүүлэлт" гэдэг хэллэг нь орон байртай байх эрхийг хамгаалсан холбогдох хуулийн заалтууд болон Пактын заалттай тэр бүр тохирохгүй гэж шүүмжилдэг. Түүнчлэн "шударга бус нүүлгэн шилжүүлэлт" гэх нь ямар ч эрх зүйн орчинд хэрэглэх боломжтой, илүү субъектив шинжтэй нэр томъёо гэсэн санал ч гарсан байдаг. Олон улсын хамтын нийгэмлэг, ялангуяа Хүний эрхийн Хороо санал болгосон эдгээр хувилбараас "албадан нүүлгэлт" гэсэн нэр томъёог хэрэглэсэн бөгөөд энэ Ерөнхий зөвлөмжид "албадан нүүлгэлт" гэсэн нэр томъёог сонгон хэрэглэсэн. Энэ нь хувь хүн, гэр бүл, олон нийт өөрсдийн амьдран суугаа орон гэр, газар нутгаасаа өөрсдийн хүсэл зоригоор бус, бүр болон түр хугацаагаар, хуулийн болон бусад зохистой хамгаалалтгүйгээр нүүлгэн шилжүүлэх явдлыг илэрхийлж байгаа болно. Гэхдээ, хуулийн дагуу болон хүний эрхийн олон улсын пактуудад заагдсан нүүлгэн шилжүүлэлтэд албадан нүүлгэлтийн хориг нь хамаарахгүй.

4. Хөгжиж буй болон хөгжингүй орнуудад албадан нүүлгэлтийг практикт өргөн хэрэглэж байгаа нь хүмүүст сөргөөр нөлөөлж байна. Хүний эрхүүд хоорондоо харилцан хамааралтай байдаг учир албадан нүүлгэх нь бусад эрхийг ч мөн адил зөрчиж байна. Энэ нь Пактаар баталгаажсан эрхийг илэрхий зөрчихийн хамт, албадан

<sup>2</sup> Хүний Суурьшил хариуцсан Хорооны 11 дүгээр хуралдааны тайлан (А/43/8/Add. 1), догол мөр 13.

<sup>3</sup> НҮБ-ын Байгаль орчин, хөгжлийн асуудлаарх бага хурлын тайлан, Рио де Жанейро, 1992 оны 6 сарын 3-14 өдөр I (А/CONF.151/26/Rev.1(vol.1), annex II, Agenda 21, chap. 7.9 (b).

нүүлгэлт нь хүний амьд явах, аюулгүй байх, халдашгүй дархан байх, хувийн амьдралд хөндлөнгөөс оролцохгүй байх, гэр бүл болон орон гэртэй байх, эд хөрөнгөө өөрийн тааваар эзэмших, энх тунх амар тайван амьдрах зэрэг иргэний болон улс төрийн эрхүүдийг мөн зөрчих шалтгаан болдог.<sup>4</sup>

5. Албадан нүүлгэх нь голдуу хүн ам ихээр суурьшин төвлөрсөн хот суурин газарт явагддаг мэт харагдаж байгаа ч хүн амыг хүчээр шилжүүлэх, дотооддоо шилжүүлэн суурьшуулах, зэвсэгт мөргөлдөөний үед хүчээр шилжүүлэн байршуулах болон бөөнөөрөө гадагш зугатах, дүрвэгчдийн хөдөлгөөний үед ч мөн адил явагддаг. Дээр дурьдсан бүх тохиолдолд шаардлагад нийцсэн орон байртай байх, мөн албадан нүүлгэлтээс ангид байх эрх нь өөр бусад олон үйлдэл, эсвэл Оролцогч Улсууд үүргээ биелүүлээгүй эс үйлдлийн улмаас зөрчигдөж болно. Шаардлагатай нөхцөл үүссэн үед хүний зарим эрхийг хязгаарлаж болох ба "зөвхөн хуульд тогтоосноор хязгаарлаж болох бөгөөд энэ нь хүний эрхийн [эдийн засаг, нийгэм, соёлын гэх мэт] мөн чанарт нийцсэн, ардчилсан нийгэм дэх нийтийн сайн сайхан байдалд тус дөхөм үзүүлэх чин зорилготой байх ёстой" гэж заасан Пактын 4 дүгээр зүйлтэй бүрэн нийцэх шаардлагатай.

6. Албадан нүүлгэлт ихэнхдээ олон улсын зэвсэгт мөргөлдөөн, дотоодын маргаан, угсаатан хоорондын зөрчилдөөнөөс улбаатай байдаг.

7. Зарим тохиолдолд албадан нүүлгэлтийг хөгжлийн төлөө нэрийн дор хийдэг. Нүүлгэн шилжүүлэлт нь усан далан барих эсвэл том хэмжээний эрчим хүчний төслүүд зэрэг дэд бүтцийн болон хөгжлийн төслүүд, хот төлөвлөлттэй холбоотой газар чөлөөлөх асуудал, орон сууцаа шинэчилэх, хотын өнгө үзэмжийг сайжруулах хөтөлбөрүүд, хөдөө аж ахуйн зорилгоор газрыг цэвэрлэх, газрыг замбараагүй дамлан наймаалах, эсвэл Олимпын тоглолт зэрэг том хэмжээний спортын арга хэмжээ зохион байгуулах зэргээр газар эзэмших эрхийн төлөөх тэмцэлтэй холбоотойгоор явагддаг.

8. Пактад оролцогч улсуудын албадан нүүлгэхтэй холбоотой хүлээх үүрэг нь Пактын 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт болон Пактын

---

<sup>4</sup> НҮБ-ын Хүн амын суурьшлын асуудлаарх Бага хурал (Habitat II) (A/CONF. 165/14), II хавсралт, Хурлын хөтөлбөр, 40 дэх догол мөр (n). 40 (n).

бусад заалтад тусгагдсан байдаг. Ялангуяа, 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт оролцогч улс бүр хүний орон байртай байх эрхийг хангахын тулд "бүх бололцооныхоо хирээр арга хэмжээ" авах үүрэгтэйг заасан. Гэвч албадан нүүлгэж байгаа практикаас харахад 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргийг Оролцогч улс хангаж чадахгүй байна. Тиймээс Оролцогч улс албадан нүүлгэх явдлаас зайлсхийж, нүүлгэн шилжүүлэлтийг хариуцсан байгууллага эсвэл гуравдагч этгээдэд мөн энэ хууль тогтоомж үйлчилж байгаа эсэхийг баталгаажуулна. (дээр дурдсан 3 дахь догол мөрөнд бичигдсэн байгаа). Нэмж хэлэхэд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт (ИУТЭОУП)-ын 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, түүний орон байрны халдашгүй байдалд хууль бусаар халдаж болохгүй" гэж заасан байдаг. Энэхүү эрхийг хамгаалах улс орнуудын үүрэг нь боломжит бүх арга хэрэгсэлийг авсан эсэхтэй нь харьцуулж үзэхэд хангалтгүй байгааг мөн тэмдэглэсэн.

9. Пактын 2 дугаар зүйлийн 1 дэх заалт оролцогч улсуудаас хууль тогтоомж батлах болон Пактаар хүлээн зөвшөөрөгдсөн бүх эрхийг бүрэн хэрэгжүүлэх "бүхий л боломжит арга хэмжээ" авахыг шаарддаг. Хороо 1990 оны Ерөнхий зөвлөмж №3-таа эдгээр арга хэмжээ нь хүний бүхий л эрхүүдэд зайлшгүй хамааралтай биш байж болохыг дурдсан. Албадан нүүлгэхийг хориглосон хууль тогтоомж нь үр нөлөөтэй хамгааллын тогтолцоо бий болгох үндэс суурь гэдэг нь тодорхой юм. Ийм хууль тогтоомж нь

- (а) орон байр, газар эзэмшлийн эрхийн аюулгүй байдлыг боломжит хамгийн дээд хэмжээнд хамгаалсан байх,
- (б) Пактад бүрэн нийцсэн байх,
- (в) болзошгүй нүүлгэн шилжүүлэлтийн нөхцөл байдлуудад хатуу хяналт тавих заалт зэргийг багтаасан байвал зохино. Уг хууль тогтоомж нь тухайн улсын эрх бүхий, мөн үүрэг хүлээсэн бүхий л албан тушаалтнуудад мөн үйлчлэх ёстой. Цаашилбал, зарим Засгийн газар байшин, орон байрны салбарт хариуцлага ихээхэн суларч байгаад анхаарлаа хандуулахын зэрэгцээ хуулийн болон бусад зохистой урьдчилан сэргийлэх арга хэмжээг баталгаажуулах, зохистой хамгаалалтгүйгээр бусдыг албадан нүүлгэсэн хувь хүмүүс болон байгууллагад шийтгэл оноох ёстой. Тиймээс оролцогч улс одоо мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичгээ эргэн харж, Пактын шаардлагуудад

нийцэхгүй байгаа хууль тогтоомж, бодлогуудаа хүчингүй болгох, эсвэл өөрчлөх шаардлагатай.<sup>5</sup>

10. Эмэгтэйчүүд, хүүхэд, залуус, өндөр настан, уугуул иргэд, үндэсний болон бусад цөөнх зэрэг эмзэг бүлгийн хүмүүс албадан нүүлгэлтээс болж давхар зовлонд унаж байна. Бүх бүлгийн, ялангуяа эмзэг бүлгийн эмэгтэйчүүд хуулиар эрхээ хамгаалуулж чадахгүй байх явдал нэмэгдэх, мөн өмчлөх эрх (орон байраа өмчлөх эрхийг оролцуулаад) эсвэл эд хөрөнгө болон орон байраа ашиглах эрхтэй холбоотойгоор ялгаварлагдаж орон гэргүй болсон үедээ хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэлд өртөж байна. Пактын 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг болон 3 дугаар зүйлд тусгагдсан алагчлахгүй байх зүйлүүд нь нүүлгэн шилжүүлэлт явагдаж байх үед ямар нэгэн хэлбэрийн алагчлах явдал гаргахгүйн тулд зохистой арга хэмжээ авах нэмэлт үүргийг Засгийн газруудад оногдуулдаг.

11. Түрээсийн төлбөрөө байнга төлөхгүй байх, эсвэл ямар нэгэн үндэслэлгүйгээр түрээсийн орон сууцанд гэмтэл учруулах зэрэг шалтгааны улмаас албадан нүүлгэж болох ба энэ тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагын албан хаагч Пактад нийцсэн, хуульд заасан арга хэмжээг үүнд өртсөн хүмүүст зохих хамгааллын арга хэрэгслийг авсны үндсэн дээр хэрэглэсэн гэдгийг баталгаажуулах ёстой.

12. Албадан нүүлгэх, орон байрыг нь нураах явдлыг залхаан цээрлүүлэх, шийтгэхийн тулд хэрэглэх нь Пактын хэм хэмжээнд үл нийцнэ. Тиймээс 1949 оны Женевийн Конвенц болон түүний 1977 оны Протоколд иргэдийг хүсэл зоригийнх нь эсрэг өөр газар шилжүүлэн суурьшуулах, нүүлгэн шилжүүлэлтийн үед хувийн эд хөрөнгийг гэмтээн сүйтгэхийг албадан нүүлгэсэнд тооцож, хориглосон заалт байдгийг Хороо тэмдэглэж байна.

13. Оролцогч улс аливаа нэг нүүлгэх үйлдлээс өмнө, ялангуяа олон хүн хамрагдаж байгаа бол, тухайн нүүлгэн шилжүүлэлтийг зогсоох, эсвэл хүч хэрэглэх шаардлагыг багасгах бүхий л боломжит хувилбаруудыг нөлөөлөлд өртсөн хүмүүстэй хамтдаа эрж хайх, зөвлөлдөх явдлыг хангах ёстой. Нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөлд

---

<sup>5</sup> Хүний эрхийн Комиссын тогтоол, 1993 оны 7-р тогтоол, 1-р догол мөр. 1.



өртсөн хэн ч хуулийн дагуу эрх сэргээлгэх, хамгаалагдах ёстой. Оролцогч улсууд нөлөөлөлд өртсөн хүмүүс үл хөдлөх болон хөдлөх хөрөнгөндөө хүрэлцээтэй хэмжээний нөхөн төлбөр авах эрхтэй эсэхийг хянаж үзэх ёстой. Энэ тохиолдолд эрх нь зөрчигдсэн хүний эрхийг "үр нөлөөтэй хамгаалах үйл ажиллагаа, болон "тухайн үйл ажиллгааг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага"-тай байх үүргийг Оролцогч улсуудад оногдуулсан "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт дурдах нь зүйтэй.

14. Нүүлгэн шилжүүлэхийг зөвшөөрч байгаа тохиолдолд, энэ нь хүний эрхийн олон улсын эрх зүйн холбогдох зохицуулалт, мөн үндэслэлтэй байх болон хэр хэмжээндээ тохирсон байх ерөнхий зарчмуудтай чанд нийцэж явагдах ёстой. Энэ нь ИУТЭОУП-ын 17 дугаар зүйлд холбогдох Хүний эрхийн Хорооны Ерөнхий зөвлөмж №16-д хамааралтай бөгөөд хүний орон байранд дур мэдэн хөндлөнгөөс халдах явдлыг зөвхөн "хуульд заасан тохиолдолд" хэрэгжүүлэх боломжтой. Тэрхүү хууль нь "Пактын зорилго, зорилт, заалтуудтай нийцсэн, ямар ч тодорхой үйл явдал, нөхцөл байдалд үндэслэлтэй байх ёстой" гэдгийг Хороо тэмдэглэсэн байна. Хороо "холбогдох хууль тогтоомж нь ямар хөндлөнгийн халдлагыг зөвшөөрч болох тухай нарийвчилсан нөхцөл байдлын талаар тусгах ёстой" гэдгийг мөн дурдсан.

15. Албадан нүүлгэлтийн үеийн зохих хамгаалалт, үйл явц нь хүний эрхийн чухал хүчин зүйл мөн бөгөөд хүний эрхийн асуудлаархи олон улсын Пактуудад тусгагдсан эрхүүдийг шууд зөрчдөг албадан нүүлгэлт гэх мэт зүйлээс хамгаалахад чиглэгдсэн байх нь зүйтэй.<sup>6</sup> Албадан нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой үйл явцын хамгаалалтыг хэрэгжүүлэхдээ

- (а) нөлөөлөлд өртсөн хүмүүстэй үр дүнтэй зөвлөлдөх боломжийг хангах,
- (б) нүүлгэн шилжүүлэлт явуулахаар төлөвлөсөн өдрөөс өмнө нөлөөлөлд өртсөн бүх хүмүүст ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр мэдэгдэх,
- (в) боломжтой бол нүүлгэн шилжүүлэх газар, ашиглахаар

<sup>6</sup> E/1998/22 тоот баримт болон, IV хавсралтанд бий.

төлөвлөсөн орон байрны талаарх мэдээллийг нөлөөлөлд өртсөн хүмүүст боломжит цаг хугацаанд нь өгөх,  
(г) ялангуяа, олон хүнийг хамарсан бол, төрийн албан тушаалтнууд эсвэл тэдний төлөөлөгчид нүүлгэн шилжүүлэлтийн үед байлцах,  
(д) нүүлгэн шилжүүлэлтийг явуулж байгаа хүмүүсийг зөв сонгох,  
(е) хүмүүс өөрсдөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд нүүлгэн шилжүүлэлтийг цаг агаар муу байхад эсвэл шөнийн цагаар явуулахгүй байх,  
(ё) хуулийн дагуу эрх хамгаалах арга хэмжээнүүдийг авсан байх,  
(ж) боломжтой бол, эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандсан хүнд эрх зүйн туслалцаа үзүүлэх зэрэг арга хэмжээг авахыг Хорооны зүгээс зөвлөдөг.

16. Нүүлгэн шилжүүлэлт нь орон гэргүй болон эмзэг бүлгийнхний эрхийг зөрчих ёсгүй. Нөлөөлөлд өртсөн хүмүүс өөрсдөө чадахгүй байгаа нөхцөлд, тэднийг шаардлагад нийцсэн орон байрны хувилбарууд болон үржил шимтэй газарт суурьших буюу тийм газар олж авах боломжоор хангахын тулд Оролцогч Улс өөрт байгаа боломжит нөөцийг дайчлан, шаардлагатай бүх арга хэмжээг авах ёстой.

17. Олон улсын байгууллагуудын санхүүжилт бүхий олон тооны хөгжлийн хөтөлбөр, төслүүд нь Оролцогч улсуудын албадан нүүлгэлт явагдсан нутаг дэвсгэр дээр хэрэгжиж байгаа талаарх мэдэгдэл Хороонд ирсэн. Тиймээс Хороо 1990 оны Ерөнхий Зөвлөмж №2-тоо "олон улсын байгууллагууд нь хувь хүмүүс, бүлгүүдийг алагчлан үзсэн эсвэл Пактанд тусгагдсан заалтуудтай зөрчилдсөн, өргөн хүрээтэй нүүлгэн шилжүүлэлтэд оролцох болон зохистой хамгаалалт, нөхөн төлбөргүйгээр хүмүүсийг шилжүүлэн байршуулах үйл ажиллагаанд оролцохоос шударгаар татгалзах ёстой"-г тэмдэглэж, хөгжлийн төслүүдийн бүхий л үе шатанд Пактад тусгагдсан эрхүүдийг зохих ёсоор хангах хүчин чармайлтыг гаргах ёстой" гэж заасан байна.<sup>7</sup>

18. Дэлхийн Банк, Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллага зэрэг зарим байгууллага албадан нүүлгэн

<sup>7</sup> / E/1990/23, III хавсралт, 6-8 дахь догол мөр. 6 and 8 (d).

шилжүүлэлттэй холбоотой хүнд учирч болох зовлон шаналалыг багасгах үүднээс, шинээр байршуулах болон шилжүүлэн суурьшуулахтай холбоотой удирдамжуудыг баталж гаргасан байдаг. Ийм туршлагауд нь далан барих болон эрчим хүчний төслүүд зэрэг томоохон хэмжээний хөгжлийн төслүүдийг дагалдаж байдаг. Пактаар хүлээсэн үүргүүдийг ийм удирдамжуудад хэдий чинээ сайн тусгаж өгөх хэрээр тухайн байгууллага болон Пактад Оролцогч улсууд аль аль нь уг удирдамжийг бүрнээ дагаж мөрддөг. Хороо энэ тухайд, Венийн Тунхаглал болон Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "хөгжил хэдийгээр хүний эрхийг хангах замд хөтөлж байгаа хэдий ч дутуу дулимаг хөгжил нь олон улсын хэмжээгээр хүлээн зөвшөөрөгдсөн эрхүүдийг хязгаарлах явдлыг зөвтгөх шалтаг болохгүй юм" гэсэн мэдэгдлийг эргэн сануулж байна. (1 дүгээр хэсэг, 10 дахь догол мөр)

19. Тайлан бичих талаар Хорооны гаргасан удирдамжаас үзвэл, Оролцогч улсууд албадан нүүлгэн шилжүүлэлтийн явцтай шууд холбоотой бүхий л мэдээллийг өгөх ёстой.<sup>8</sup> Үүнд:

- (а) "сүүлийн 5 жилийн хугацаанд нүүлгэн шилжүүлэгдсэн хүний тоо, мөн сүүлийн үед дур зоргын болон бусад хэлбэрийн нүүлгэн шилжүүлэлтийн эсрэг хуулийн хамгаалалт авч чадаагүй хүний тоо",
- (б) "эзэмшлийн аюулгүй байдал, оршин суугчдын нүүлгэн шилжүүлэлтээс хамгаалагдах эрхийн талаарх хууль тогтоомжийн мэдээлэл",
- (в) "аливаа хэлбэрийн нүүлгэн шилжүүлэлтийг хориглосон хууль тогтоомжийн мэдээлэл" зэрэг багтана.

20. Эдгээр мэдээллийг "хот шинэчлэлийн болон дахин төлөвлөлтийн хөтөлбөрүүд, газрыг сайжруулан тохижуулах, олон улсын арга хэмжээний бэлтгэл (Олимпын тоглолт болон бусад спортын тэмцээн, үзэсгэлэн, бага хурал, "ухаалаг хот" кампанит ажил гэх мэт)-ын үед нүүлгэн шилжүүлэлтээс хамгаалах баталгаа, болон нөлөөллийн бүсэд юмуу, бүсийн ойролцоо амьдарч байгаа хүмүүстэй харилцан тохиролцож хийсэн дахин орон байртай болгох амлалт зэргээс хайх хэрэгтэй".<sup>9</sup>

<sup>8</sup> /Е/С. 12/1999/8, IV хавсралт

<sup>9</sup> мөн тэнд

Гэвч цөөхөн Оролцогч улс Хороонд өгсөн тайландаа шаардлагатай мэдээллийг тусгадаг. Иймээс, Хороо ийм мэдээллийг хүлээн авахын ач холбогдлыг тэмдэглэхийг хүсч байна.

21. Зарим Оролцогч улс ийм төрлийн мэдээлэл өгөх боломжгүй гэж мэдэгдсэн байдаг. Холбогдох Засгийн газар болон Хорооны аль аль нь шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн хэрэгжилтэнд үр дүнтэй хяналт тавихад шаардлагатай мэдээлэл цуглуулах боломжтой бөгөөд бүх Оролцогч улсууд Пактаар хүлээсэн үүргийнхээ дагуу шаардлагатай мэдээллийг цуглуулж, тайландаа тусган, илгээх ёстой.

**ХӨГЖИЛД СУУРИЛСАН НҮҮЛГЭЛТ  
БОЛОН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ  
ТАЛААРХ ҮНДСЭН ЗАРЧИМ,  
УДИРДАМЖ**

**A/HRC/4/18**

## ГАРЧИГ

ХАМРАХ ХҮРЭЭ, МӨН ЧАНАР	29
ЕРӨНХИЙ ҮҮРЭГ	32
Үүрэг хүлээгчид ба үүргийн мөн чанар	32
Хүний эрхийн үндсэн зарчим	33
Улс орнуудын үүргийн хэрэгжилт	34
Урьдчилан сэргийлэх бодлого, стратеги, хөтөлбөр	37
Нүүлгэн шилжүүлэхийн өмнө	38
I. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙН ҮЕД	41
II. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙН ДАРАА: ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ БА ШИЛЖҮҮЛЭН БАЙРШУУЛАХ	42
III. АЛБАДАН НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙН ҮЕД АВАХ ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ	46
А. Нөхөн олговор	46
В. Гэм хорыг арилгах ба эргэн ирэх	47
С. Дахин суурьшуулалт ба хэвийн амьдралдаа эргэн орох	48
IV. ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ БОЛОН ЭРГЭН ХЯНАХ	48
V. ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУД, ОЛОН УЛСЫН ХАМТЫН НИЙГЭМЛЭГИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ	49
VI. ТАЙЛБАР	49

## 1. ХАМРАХ ХҮРЭЭ, МӨН ЧАНАР

1. Улс орнууд олон улсын эрх зүйн хэд хэдэн баримт бичгүүдэд тусгагдсан шаардлагад нийцсэн орон байраар хангагдах болон холбогдох бусад эрх болох хүнийг орон байр, газраас нь албадан нүүлгэн шилжүүлэхээс хамгаалах, түүнээс татгалзах үүрэгтэй. Эдгээрт Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт (11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг), Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн (27 дугаар зүйлийн 3 дахь хэсэг), Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн алагчлахгүй байх тухай заалтууд, Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын Конвенцийн 5 дугаар зүйлүүд тус тус багтана.

2. Түүнчлэн хүний эрхийн үл хуваагдах чанарт нийцүүлэн Иргэний болон Улс төрийн Эрхийн тухай Олон Улсын Пактын 17 дугаар зүйлд “хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, түүний орон байрны халдашгүй байдал болон захидал харилцааны нууцад халдаж болохгүй” гээд “хүн бүр ийм хөндлөнгийн оролцоо болон халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй” гэж заажээ. Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт мөн ижил агуулгатай заалт бий. Олон улсын эрх зүйн баримт бичгүүд дэх холбогдох бусад заалтыг дурдвал, Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай 1951 оны Конвенцийн 21 дүгээр зүйл, Тусгаар тогтносон улсуудын уугуул болон овог аймгийн иргэдийг хамгаалах тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ)-ын (1989 оны) 169 дүгээр Конвенцийн 16 дугаар зүйл, Дайны үед энгийн иргэдийг хамгаалах тухай 1949 оны 8-р сарын 12-ны өдрийн Женевийн Конвенц (Женевийн 4 дүгээр Конвенц)-ийн 49 дүгээр зүйл зэрэг болно.

3. Энэ удирдамж нь бүтээн байгуулалтаас үүдсэн албадан нүүлгэлт, хот суурин болон орон нутаг дахь холбогдох хүчээр нүүлгэн шилжүүлэлтийн үеийн хүний эрхийн асуудлуудыг зохицуулахыг зорьсон юм. Энэ удирдамж нь хөгжилд суурилсан нүүлгэлт болон шилжилт хөдөлгөөний талаарх үндсэн зарчим, удирдамжийн хөгжилд нөлөөлөх болно. Эдгээр нь хүний эрхийн олон улсын эрх зүйд суурилсан, ЭЗНСЭ-ийн Хорооны Ерөнхий зөвлөмжтэй (№7, 1997 он) нийцсэн, Дотоодын шилжүүлт

хөдөлгөөний талаарх баримтлах зарчмууд (EE/CN.4/1998/53/Add.2), Ерөнхий Ассамблейн 60/147 дугаар тогтоолоор баталсан Хүний эрхийн олон улсын эрх зүйн хэм хэмжээг бүдүүлгээр зөрчснөөс болон олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн хэм хэмжээг ноцтой зөрчснөөс болж хохирогсдын эрхийг хуулиар хамгаалах, нөхөн төлбөр олгох Ерөнхий зарчим болон удирдамж, мөн Дүрвэгсэд болон шилжин суурьшигчдын орон байр, эд хөрөнгийг нөхөн сэргээх талаар баримтлах зарчмуудад үндэслэсэн болно. (E/CN.4/Sub.2/2005/17 болон Add.I-г үз).

4. Хүний эрхийн олон улсын хэм хэмжээнд тусгагдсан “албадан шилжүүлэлт”-тэй холбоотой бүхий л тодорхойлолт амьдралд хэрэгжихдээ хувь хүмүүс, бүлэг болон орон нутгийнхан эзэмшдэг эсвэл амьжиргаагаа залгуулдаг газар гэр орноос нь хүч хэрэглэн, сүрдүүлж эсвэл өөрийнх нь хүсэл зоригийн эсрэг нүүлгэж байгаа гэдгийг анхаарч үзэх ёстой. Энэ нь хувь хүн, бүлгийн тодорхой газар орон, байр сууцанд ажиллаж, амьдрах, хуулийн болон бусад зохистой хамгаалалт авах боломж, нөхцөлийг хязгаарлаж, эсвэл үгүй хийж байна.<sup>1</sup>

5. Албадан нүүлгэлт нь олон улсын эрх зүйн хүрээнд бий болсон тодорхойлолт бөгөөд энэ нь ихэнхдээ шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхийн чухал хэсэг болох үл хөдлөх хөрөнгө эзэмших эрхээ хуулийн дагуу бүрэн эдэлж чадахгүй байгаатай холбоотой байдаг. Албадан нүүлгэлт нь хүн амыг шилжүүлэх, олноор нь албадан гаргах, нэгэн зэрэг бөөнөөр нь нүүлгэх, яс үндсээр нь ялгаварлан шахан зайлуулах болон хүмүүсийг өөрсдийнх нь орон гэр, газар, орон нутгаас нь хүчээр шахан гаргах зэрэг бусад тохиолдлуудтай ижил үр дагаврыг авчирдаг.

6. Албадан нүүлгэлт нь шаардлагад нийцсэн орон байр, хоол хүнс, ус, эрүүл мэнд, боловсрол, ажилтай байх, хувийн аюулгүй байдал, орон гэрийн халдашгүй байдал, түүнчлэн хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцахаас хамгаалуулах, амьдрах газраа чөлөөтэй сонгох зэрэг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхүүдийг бүдүүлгээр зөрчиж байна. Нүүлгэн шилжүүлэлтийг хууль ёсны дагуу, зөвхөн зайлшгүй тохиолдолд,

---

<sup>1</sup> Албадан нүүлгэлтийн энэ хориг олон улсын хүний эрхийн гэрээнүүд болон түүнд нийцсэн хуулийн дагуу явуулж буй нүүлгэн шилжүүлэлтийн аль алинд нь хамаарахгүй.



хүний эрхийн олон улсын эрх зүй болон хүмүүнлэгийн эрх зүйн холбогдох баримт бичгүүдэд заасны дагуу явуулна.

7. Албадан нүүлгэлт нь зөрчилдөөн, ялгаварлал, “хүмүүсийг нийгмийн байдал, үндэс угсаагаар нь ялгаварлаж, тодорхой хэсэг газарт амьдрахад хүргэх” зэрэг нийгэм дэх тэгш бус байдлыг улам дэвэргэж, энэ нь ядуус, хүүхэд эмэгтэйчүүд, үндэсний цөөнх, уугуул иргэд зэрэг нийгмийн болон эдийн засгийн хувьд эмзэг, орхигдсон бүлгийнхэнд байнга хүндээр тусдаг.

8. Энэхүү удирдамжийн агуулгыг харвал, бүтээн байгуулалтын шаардлагаар хийгдэж буй нүүлгэн шилжүүлэлт нь ихэвчлэн урьдчилан төлөвлөгдсөн, “нийтийн сайн сайхан”-ыг шалтгаа болгосон байдаг. Эдгээрт хөгжлийн болон дэд бүтцийн төслүүд (томоохон хэмжээний далан барих, аж үйлдвэрийн, эрчим хүчний төслүүд, уул уурхай болон олборлох үйлдвэрлэлийн төслүүд), хотыг шинэчлэх, ядуучуудын хорооллыг сайжруулах, барилгажилт явуулах, хотын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх, эсвэл газар ашиглалттай холбоотой бусад хөтөлбөр (хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглах гэх мэт) зэрэг газрыг нөхөх олговортойгоор өмчлөгчөөс нь авахтай холбоотой арга хэмжээ, хөрөнгө, үл хөдлөх хөрөнгө болон газрын маргаан, хянаж чадахгүй байгаа газрын дамын наймаа, олон улсын болон спортын арга хэмжээ зохион байгуулах, эсвэл байгаль хамгаалах нэрийдлээр газрыг нь авах зэрэг багтаж байгаа юм. Ийм үйл ажиллагааг олон улсын хөгжлийн тусламжийн хүрээнд хүртэл дэмжсэн байх нь бий.

9. Хүний эрхийн болон хүмүүнлэгийн одоогийн байгаа хэм хэмжээг үл харгалзан байгаль орчны доройтол, сүйрлээс болж хүмүүс орон гэрээсээ дүрвэж нүүхэд хүрч байгаа бол нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, байгалийн болон хүний хүчин зүйлээс хамааралтай гамшиг, хурцадмал байдал, үймээн самуун, дотоодын болон улс дамнасан зөрчил онцгой байдлаас болж хүмүүсийг нүүлгэн шилжүүлдэг. Мөн түүнчлэн гэр бүлийн хүчирхийлэл, соёл, уламжлалтай холбоотой зарим нэг зан заншлын улмаас хүмүүсийг албадан нүүлгэх, шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг оролцуулаад хүний эрхийг зөрчих нь элбэг тохиолдож байна. Ийм нөхцөлийг энэ удирдамжинд тодорхой тусгаагүй ч зарим нэмэлт асуудлуудад нөлөөлж мэдэх тухайлбал дүрвэгсэд, орон гэргүй хүмүүст орон байр, эд хөрөнгийн нөхөн

олговор олгох асуудал руу анхаарал хандуулсан. Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсөнөөс болж хүний эрхийн эрх зүйг бүдүүлгээр хохирсон иргэдийн эрхийг сэргээн эдлүүлэхэд баримтлах үндсэн зарчим болон Удирдамж, Дотоодын шилжилт хөдөлгөөний талаар баримтлах зарчим, Дүрвэгсэд болон шилжин суурьшигчдын орон байр, эд хөрөнгийг нөхөн сэргээх талаар баримтлах зарчмуудыг тус удирдамжинд тусгасан.

10. Энэ нь Дотоодын шилжилт хөдөлгөөний талаар баримтлах зарчмын 6 дахь хэсэгтэй тохирч байна. Албадан нүүлгэлт өргөн хүрээтэй явагдаж байгааг онцлохын зэрэгцээ одоогийн удирдамжууд нь бүтээн байгуулалтын шаардлагаар хийгдэж буй нүүлгэн шилжүүлэхдээ “албадан нүүлгэлт”-ийг хуульчлахгүй байх, хүчин төгөлдөр үйлчилж байгаа олон улсын хүний эрхийн хэм хэмжээг зөрчихгүй байх арга хэмжээ авч, процедур бий болгохыг Улс орнуудад зөвлөмжлөхөд чиглэж байгаа юм. Эдгээр удирдамж нь албадан нүүлгэлт явуулахгүй байх, эрх нь зөрчигдсөн болон эрхээ хамгаалуулж чадаагүй хүн бүрийн эрхийг үр нөлөөтэй сэргээн хамгаалах арга хэмжээг баталгаажуулсан бодлого, хууль тогтоомж, хэрэгжүүлэх процедурыг боловсруулахад нь Улс орнууд, байгууллагуудад зааварчилгаа өгөхөд чиглэгдэж байгаа юм.

## **II. ЕРӨНХИЙ ҮҮРЭГ**

### **A. Үүрэг хүлээгчид ба үүргийн мөн чанар**

11. Өөр өөр оролцогчид албадан нүүлгэх, газар чөлөөлөх дээр харилцан адилгүй хориг, хэрэгцээ шаардлага, хүсэлт гаргах, бүр үл тоож, эсвэл буулт хийж мэдэх ч, улс орнууд гэрээнд заавал биелүүлэхээр заасан эрхийг хамгаалах, хүний эрх, хүмүүнлэгийн хэм хэмжээг хүндэтгэж байгаагаа баталгаажуулахын тулд энэ удирдамжид тусгагдсан олон улсын нийтийн эрх зүйн ерөнхий зарчмуудыг хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг. Гэхдээ энэ нь төслийн менежерүүд, хувь хүн, олон улсын санхүүгийн болон бусад байгууллага, үндэстэн дамнасан болон бусад корпораци, мөн газрын эзэд, газраа түрээслүүлэгчид зэрэг хувь хүмүүсийн бүгдийнх нь хариуцах асуудал юм.

12. Олон улсын эрх зүйн дагуу улс орнууд хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, хангах үүрэгтэй. Энэ нь улс орнууд

дотооддоо болон бусад улсын нутаг дээр хүний эрхийг зөрчихөөс татгалзах, улсын шүүх эрх мэдлийн хамаарах газар нутгийн доторх бусад оролцогч талууд бусдын эрхийг зөрчихгүй байхад үр дүнтэй хяналт тавьдаг байх, хүний эрхийг хөхүүлэн дэмжих, эрх нь зөрчигдсөн хүмүүст туслалцаа үзүүлэх, урьдчилан сэргийлэх болон шүүхээр хамгаалах арга хэмжээг авах ёстой гэсэн үг юм. Эдгээр үүрэг нь тасралтгүй бөгөөд нэгэн зэрэг хэрэгжих шинжтэй бөгөөд шатлан захирах арга хэмжээг санал болгодоггүй.

## **В. Хүний эрхийн үндсэн зарчмууд**

13. Олон улсын хүний эрхийн эрх зүйн дагуу хүн бүр шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг оролцуулаад амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрхтэй. Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх нь хүний хувийн халдашгүй байдал, гэр бүл, хувийн эзэмшлийн аюулгүй байдалд дур мэдэн эсвэл хууль бусаар халдахаас хамгаалуулах эрхийг мөн багтаадаг.

14. Олон улсын эрх зүйн дагуу Улс орнууд шаардлагад нийцсэн орон байртай байх, хувийн эзэмшлийн аюулгүй байдлыг хангах эрхийг хэрэгжүүлэхдээ угсаа гарвал, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, итгэл үнэмшил, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс угсаа, нийгмийн гарал, эрх зүйн болон нийгмийн байдал, хөрөнгө чинээ, төрөлхийн болон бусад байдлаар алагчилахгүй байх явдлыг баталгаажуулахаас гадна албадан нүүлгэлтийн эсрэг хамгаалалтыг бий болгох ёстой.

15. Улс орнууд одоогийн удирдамжуудад заасны дагуу албадан нүүлгэх үед эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн эрх тэгш байдал, шаардлагад нийцсэн орон байртай байх болон хувийн эзэмшлийн аюулгүй байдлыг хамгаалах эрхийг ижил хэмжээнд эдэлж байгаа эсэхэд хяналт тавих ёстой.

16. Хүн бүр дахин суурьшихдаа хангалттай хүрэлцэхүйц, хүртээмжтэй, боломжийн үнэтэй, амьдарч болохуйц, эзэмшлийн аюулгүй байдлыг хангасан, соёлын хувьд нийцтэй, боломжийн байршилтай, эрүүл мэнд, боловсролын зэрэг нийгмийн суурь үйлчилгээ авах бололцоотой байх зэрэг эрхүүдийг эдлэх эрхтэй.

17. Улс орнууд, албадан нүүлгэлтийн үед хамгаалуулах эрх

нь зөрчигдсөн хэмээн гомдол гаргасан хүн бүрийн эрхийг эрх зүйн болон бусад арга хэрэгслээр үр нөлөөтэй, хүртээмжтэйгээр хамгаалах явдлыг баталгаажуулах ёстой.

18. Улс орнууд албадан нүүлгэлт явуулахгүй байх хуулийн заалт эсвэл бодит байдалтай холбогдуулан ямар нэгэн ухралт хийх, эсвэл дордуулсан арга хэмжээг зориудаар авахаас татгалзана.

19. Улс орнууд албадан нүүлгэлтийн хориг нь нөлөөлөлд өртсөн хүн амын гарал угсаа, шашин шүтлэг, төрөл гарлаас хамаарч өөрчлөгддөг болохыг хүлээн зөвшөөрнө.

20. Улс орнууд хөгжлийн албан ёсны тусламж эрэлхийлэх болон хэрэгжүүлэхдээ хүний эрхийн талаар хүлээсэн үүргийнхээ дагуу нухацтай төлөвлөн хийнэ.

### **С. Улс орнуудын үүргийн хэрэгжилт**

21. Улс орнууд нүүлгэн шилжүүлэлтийг зөвхөн онцгой нөхцөлд л зөвшөөрч, баталгаажуулна. Ингэхдээ олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхэд үзүүлэх нөлөөллийг өргөн хүрээнд харгалзсан байх шаардлагатай. Нүүлгэн шилжүүлэлт бүр

- (а) хуулиар зөвшөөрөгдсөн байх,
- (б) хүний эрхийн олон улсын эрх зүйн дагуу явагдсан байх,
- (в) зөвхөн бүх нийтийн сайн сайхны тусын тулд хийгдсэн байх,
- (г) шалтгаан нөхцөлдөө дүйцсэн байх,
- (д) хэвийн амьдралдаа эргэн ороход шаардлагатай бүрэн, шударга нөхөх олговрыг баталгаажуулж хуульчилсан байх,
- (е) энэ удирдамжуудын дагуу явагдсан байх ёстой.

Хэрэгжүүлэлтэнд тавигдаж буй эдгээр хамгаалалт нь эмзэг бүлгийн бүх хүмүүс болон нөлөөлөлд автсан иргэдэд дотоодын хууль тогтоомжийн дагуу гэр орон, эд хөрөнгөтэй байхаас үл хамааран үйлчилнэ.

22. Улс орнууд олон улсын өмнө хүлээсэн хүний эрхийг хангах үүргүүдтэйгээ үл нийцэх нүүлгэн шилжүүлэлт явуулахыг хориглосон эрх зүйн болон бодлогын арга хэмжээ авна. Гэр орон, газраа

чөлөөлөхийг шаардах, эсвэл хураан авах ажиллагаа хүнийг эрхээ эдлэхэд нь саад болж байгаа нөхцөлд Улс орнууд бүхий л боломжит хэлбэрээр татгалзвал зохино. Тухайлбал, нүүлгэн шилжүүлэлт нь газрын шинэтгэл болон дахин хуваарилалттай холбоотойгоор хийгдэж байгаа, ялангуяа эмзэг бүлгийн болон ядуу хүн, бүлэг, тухайн газарт амьдарч буй хүмүүсийн тусын тулд явагдаж байгаа бол хэрэгжүүлж болох юм. Улс орнууд аливаа нийтийн болон хувийн хуулийн этгээдийн эсрэг зүй зохистой иргэний болон эрүүгийн санкцыг хэрэглэвэл зохино. Эдийн засаг, Нийгэм, Соёлын Эрхийн Хорооны 1991 онд баталсан Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн тухай 4 дэх ерөнхий санал зөвлөмжийг үзнэ үү.

Энэхүү удирдамж дахь бүх нийтийн сайн сайхны тусын тулд гэдгийг Улс орнууд олон улсын өмнө хүлээсэн хүний эрхийг хангах үүргээ, биелүүлэх ялангуяа нэн эмзэг бүлгийн хүмүүсийн эрхийг хангаж хамгаалахад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг ойлгоно.

23. Улс орнууд хүн бүрийн шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг адил тэгш эдлэх боломжийг хангахын тулд өөрт байгаа боломжит бүхий л нөөцийг шавхан дайчилбал зохино. Улс орнууд хүчин төгөлдөр үйлчилж байгаа олон улсын хүний эрхийн хэмжээнд нийцээгүй нүүлгэн шилжүүлэлтээс хувь хүн, бүлэг, орон нутгийнхны эрхийг эрх зүйн болон бодлогын зохистой арга хэмжээг бий болгох замаар хамгаалах үүргээ нэн даруй биелүүлбэл зохино.<sup>23</sup>

24. Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхээ эдлэхэд сөргөөр нөлөөлж байгаа эсэх, хуулийн дагуу болон хууль бус ямар нэгэн хэлбэрээр алагчилж үзээгүй гэдгийг баталгаажуулахын тулд Улс орнууд үндэсний холбогдох хууль тогтоомж болон бодлогоо цогцоор нь эргэн харах ёстой. Ингэхдээ одоогийн хууль тогтоомж, нийтийн үйлчилгээг хувьчлахад баримтлах бодлого, өв залгамжлал, зан заншил зэрэг нь албадан нүүлгэлтийн шалтгаан болоогүй болохыг хянаж, баталгаажуулсан байна.

<sup>2</sup> Эдийн засаг, Нийгэм, Соёлын Эрхийн Хороо, Ерөнхий зөвлөмж №3 (1990 он) Оролцогч улсуудын хүлээх үүргүүдийн мөн чанарын талаар.

<sup>3</sup> Хүний эрхийн Тусгай Илтгэгчийн шаардлагад нийцсэн орон байртай байх нь 2002 оны тайланд багтсан орон байр болон алагчилж үзэх гэсэн хэсгийн удирдамжийг үз. (E/CN.4/2002/59).

25. Улс орнууд өөрийн нутаг дэвсгэр дээр албадан нүүлгэн шилжүүлэгдсэн бүх хүнийг үр нөлөөтэй хуулийн хамгаалалтанд баталгаатай авахын тулд холбогдох, хууль, дүрэм журмууд нь олон улсын хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх дээр цогцоор нь эргэн хянаж, дүн шинжилгээ хийх ёстой. Энэ цогц хяналт нь одоо үйлчилж буй хууль тогтоомж нь нийтийн үйлчилгээг хувьчлах, уламжлал зан заншлууд нь албадан нүүлгэлтийн шалтгаан болохгүй байхыг баталгаажуулах бодлогын баримтална.

26. Улс орнууд шаардлагад нийцсэн орон байртай байх эрхээ хүйс үл хамааран тэгш эдэлж байгаад хяналт тавих ёстой. Энэ нь албадан нүүлгэн шилжүүлэлтийн үед эмэгтэйчүүдийг хамгаалах онцгой арга хэмжээ авахыг Улс орнуудаас шаардаж буй хэрэг юм. Эдгээр арга хэмжээ нь орон байр болон газар эзэмших эрх бүх эмэгтэйчүүдэд олгогдсон эсэхийг баталгаажуулах ёстой.

27. Улс орнуудын заавал биелүүлэх хүний эрхийн хэм хэмжээ нь худалдаа, хөрөнгө оруулалт, хөгжлийн туслалцаа, олон талт байгууллага болон яриа хэлэлцээрт оролцох зэргийг багтаасан олон улсын харилцаатай уялдсан байвал зохино. Улс орнууд хандивлагч болон ашиг шим хүртэгч аль нь ч байсан олон улсын хамтын ажиллагааг харгалзан үзэж, хүний эрхийг хангах үүргээ биелүүлэх ёстой. Өөрийнхөө харъяалах нутаг дэвсгэрийн хүрээнд холбогдох хууль болон олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд бүрэн нийцээгүй аргаар нүүлгэн шилжүүлсэн бол Улс орнууд албадан нүүлгэхийг эсэргүүцсэн, зовлон зүдгүүр амссан, эмзэг хэвээрээ үлдсэн хүн бүрийг шаардлага хангасан, үр нөлөөтэй эрх зүйн болон бусад зохистой хамгаалалтад авах ёстой. Олон улсын байгууллагууд энэхүү удирдамж болон олон улсын эрх зүйд бүрэн нийцээгүй нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой байж болох ямар нэгэн бодлого, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, санхүүжүүлэхээс татгалзах тухайгаа мэдэгдэж байх явдлыг Улс орнууд баталгаажуулна.<sup>4</sup>

---

<sup>4</sup> ХЭТТ-ын 22 дугаар зүйл, НҮБ-ын дүрмийн 55, 56 дугаар зүйлүүд, ЭЗНСЭОУП-ын 1, 11, 15, 22 болон 23-р зүйлүүд, Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн 23 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу

## **D. Урьдчилан сэргийлэх стратеги, бодлого, хөтөлбөрүүд**

28. Улс орнууд өөрт байгаа боломжит нөөцийг шавхан, хувь хүн, бүлэг, орон нутгийнхныг албадан нүүлгэлт болон түүний үр дагавраас үр нөлөөтэй хамгаалах зохистой стратеги, бодлого, хөтөлбөрүүдийг батлах ёстой.

29. Улс орнууд холбогдох стратеги, бодлого, хөтөлбөрүүдээ олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг иж бүрнээр нь хянан үзэх ёстой. Ийнхүү хянан үзэхдээ эмэгтэйчүүд, гадуурхагдсан хүмүүс, эмзэг бүлгийнхэнд сөргөөр нөлөөлж байгаа одоогийн тэгш бус байдлыг хэвээр нь хадгалахад нөлөөлж байгаа эсвэл дордуулж байгаа заалтуудыг халах хүчин чармайлт гаргах ёстой юм. Засгийн газрууд бодлого, хөтөлбөрүүдээ хот, хөдөөд ядуу нөхцөлд амьдарч байгаа хүмүүсийг гадуурхаж, алагчилалгүйгээр боловсруулж, хэрэгжүүлэх явдлыг хангах тусгай арга хэмжээг авах ёстой.

30. Улс орнууд газар болон үл хөдлөх хөрөнгийн дамын наймаа зэрэг албадан нүүлгэн шилжүүлэлтийн үндсэн шалтгааныг багасгах, эсвэл зайлсхийх урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой. Улс орнууд орон байр болон түрээсийн зах зээлтэй холбоотой үйл ажиллагаа, дүрэм журмаа хянан үзэж, шаардлагатай бол, албадан нүүлгэн шилжүүлэлтийн үед орлого багатай болон бусад гадуурхагдсан бүлгийнхний эмзэг байдлыг нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээг зах зээлийн зохицуулалтад хөндлөнгөөс авах хэрэгтэй. Орон сууц, газрын үнэ өссөн үед Улс орнууд оршин суугчдын шаардлагад нийцсэн орон байр мөн газраа алдах буюу орхин явах зэргээр биет болон эдийн засгийн дарамтанд орохоос хангалттай хэмжээнд хамгаалах явдлыг баталгаажуулах ёстой.

31. Орон сууц, газрыг өндөр настнууд, хүүхдүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг эмзэг бүлгийнхэнд тэргүүн ээлжинд олгох ёстой.

32. Улс орнууд шилжүүлэн суурьшуулах явдлыг багасгах стратегийг нэн түрүүнд эрэлхийлэх ёстой. Бүтээн байгуулалтаас үүдсэн нүүлгэн шилжүүлэлт болон шилжүүлэн суурьшуулах ямар ч төслийг эхлэхийн өмнө цогц, иж бүрэн нөлөөллийн үнэлгээг хийж,

нөлөөлөлд өртөж болзошгүй бүхий л хүмүүсийн эрхийг хэрхэн хамгаалах асуудлыг судалсан байх ёстой, үүнд тэднийг албадан нүүлгэхээс хамгаалах асуудал багтана. “Нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөл”-ийн үнэлгээ нь хор уршгийг багасгах боломжит хувилбарууд болон стратегийг мөн багтаасан байх ёстой.

33. Нөлөөллийн үнэлгээ хийхдээ албадан нүүлгэлт нь эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настан, нийгмийн бусад гадуурхагдсан бүлгийнхэнд харилцан ялгаатай нөлөө үзүүлдгийг анхаарч үзнэ. Энэ төрлийн бүх үнэлгээ нь ялгаатай нөлөөллүүдийг зохистойгоор тодорхойлж, илэрхийлэх нарийвчилж задласан тоон мэдээлэл дээр үндэслэвэл зохино.

34. Хуульчид, хууль сахиулах байгууллагын ажилтнууд, хотын болон бүс нутгийн бодлого төлөвлөгчид зэрэг хөгжлийн төслүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх шатанд оролцдог бусад албан тушаалтан, мэргэжилтнүүдэд зориулж хүний эрхийн олон улсын хэм хэмжээг танилцуулсан иж бүрэн сургалтыг явуулах хэрэгтэй. Үүнд эмэгтэйчүүдийн эрхийн талаарх сургалт орох ёстой ба тэдний гэр орон болон газартай хамааралтай тодорхой сонирхол, шаардлагууд байдгийг онцгойлон үзэх ёстой.

35. Улс орнууд албадан нүүлгэн шилжүүлэлтээс хамгаалахтай холбоотой бодлого, хууль, хүний эрхийн талаарх мэдээллийг олон нийтэд хангалттай хэмжээнд тараан түгээж байгаа эсэхийг нягталж үзэх ёстой. Мэдээллийг нүүлгэн шилжүүлэлтэд эмзэг байгаа бүлгийнхэнд цаг алдалгүй, соёлын хувьд зохистой арга, хэлбэрээр хүргэхэд онцгой анхаарна.

36. Улс орнууд хувь хүн, бүлэг, нийтлэгтэй холбоотой тодорхой нэг тохиолдлыг үндэсний, бүс нутгийн болон олон улсын байгууллага шалгаж байх тухайн үед нүүлгэн шилжүүлэхгүй байх явдлыг баталгаажуулах ёстой.

## **М. Нүүлгэн шилжүүлэхийн өмнө**

37. Хот, хөдөөгийн төлөвлөлт, хөгжлийн үйл явц нь нөлөөлөлд өртөж болзошгүй тэрхүү хүмүүст заавал нөлөөлдөг ба дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг агуулж байдаг. Үүнд:



(а) Өртөгдөх магадлалтай бүх хүнд нүүлгэхээр төлөвлөж байгаа болон санал болгож буй төлөвлөгөө, хувилбаруудын талаар нийтийн сонгол явуулах гэж байгаа тухайгаа зохистой хэлбэрээр мэдээлэх,  
(б) Газартай холбоотой бичиг баримт болон эмзэг бүлгийнхний эрхийг хамгаалах талаар нарийвчлан тусгасан нүүлгэлтийн иж бүрэн төлөвлөгөөг багтаасан холбогдох мэдээллийг хариуцсан албан тушаалтан урьдчилан мэдээлэх,  
(в) олон нийтэд төлөвлөгөөтэй танилцах, саналаа өгөх, татгалзах хангалттай хугацаа өгөх,  
(г) Нөлөөлөлд өртсөн иргэнийг эрхийнхээ болон боломжит хувилбаруудын талаар хууль зүй, техникийн болон бусад зөвлөгөө авах боломжоор хангах  
(д) Нүүх шийдвэртэй холбоотойгоор нөлөөлөлд өртсөн хүн болон түүний хууль ёсны төлөөлөгчийн оролцоог хангасан хөгжлийн тэргүүлэх чиглэл болон тэдний шаардлагыг авч хэлэлцэх өөр боломжит хувилбаруудыг сонгох олон нийтийн сонгол явуулах,

38. Улс орнууд нүүлгэн шилжүүлэлтийн бүхий л боломжит хувилбарыг судалж үзнэ. Эмэгтэйчүүд, нутгийн уугуул иргэд, хөгжлийн бэрхшээлтэй болон нөлөөлөлд өртсөн хүмүүсийн өмнөөс ажиллаж байгаа бусад хүн зэрэг нөлөөлөлд өртөж болзошгүй бүх хүн, бүлгүүд мөн адил бүхий л явцын турш мэдээлэл, зөвлөгөө авах, оролцох, холбогдох албан тушаалтнуудад анхаарвал зохих боломжит хувилбаруудаа санал болгох эрхтэй. Холбогдох талууд санал болгосон хувилбар дээр тохиролцоонд хүрч чадахгүй бол шүүх, тусгай шүүх, арбитр, гомдол хянан үздэг хараат бус хөндлөнгийн байгууллагын төлөөлөл зэрэг үндсэн хуулиар эрх олгогдсон бие даасан байгууллагуудад хандаж, эвлэрүүлэн зуучлах, арбитрын журмаар, эсвэл шүүхийн журмаар маргаанаа шийдвэрлүүлэх зэргийн аль тохиромжтойг нь сонгоно.

39. Төлөвлөлтийн явцад нөлөөлөлд өртөгдсөн хүмүүсийг бүрэн хамруулсан зөвлөгөө, харилцан яриа явуулах боломжуудыг өргөн хүрээнд, үр нөлөөтэй олгохоос гадна шаардлагатай бол эмэгтэйчүүд, эмзэг болон гадуурхагдсан хүмүүст тусгайлсан арга хэмжээ, журам хэрэгжүүлэх хэрэгтэй.

40. Нүүлгэн шилжүүлэлт явуулах аливаа шийдвэр гаргахын

өмнө эрх бүхий албан тушаалтнууд тухайн нүүлгэн шилжүүлэлт нь зайлшгүй хийгээд нийтийн сайн сайхныг хамгаалах олон улсын хүний эрхийн амлалтуудтай нийцсэн болохыг нотлон харуулах ёстой.

41. Нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр нь хамааралтай бүх хүнд ойлгогдохоор, орон нутгийн хэлээр, бичгээр гарч, хангалттай хугацааны өмнө мэдээлэгдсэн байх ёстой. Нүүлгэн шилжүүлэлт явуулах тухай мэдэгдэл нь тухайн шийдвэрийн үндэслэлийг дэлгэрэнгүй тайлбарласан байвал зохино. Үүнд:

- (а) өөр боломжит хувилбар байхгүй байгаа тухай,
- (б) санал болгож буй хувилбарын тухай дэлгэрэнгүй мэдээлэл,
- (в) өөр хувилбар байхгүй тохиолдолд нүүлгэн шилжүүлэлтээс үүдэлтэй сөрөг үр дагавруудыг багасгах болон урьдчилан харсан бүхий л арга хэмжээг авсан тухай зэрэг болно.

Эцсийн бүх шийдвэрийг захиргааны болон хууль зүйн хяналтаар нягталж үзвэл зохино. Нөлөөлөлд өртсөн талуудад хууль зүйн зөвлөгөөг цаг алдалгүй, шаардлагатай бол үнэ төлбөргүй өгнө.

42. Мэдэгдэл өгөхдөө нүүлгэн шилжүүлэлтийн үед хөрөнгө оруулалт болон хохирол учирч болзошгүй бусад материаллаг эд зүйл зэрэг эд хөрөнгөө үнэлэх, жагсаалт гаргах боломжийг олгох ёстой. Мөнгөөр үнэлэх боломжгүй хохирлыг нөхөн төлүүлэхээр үнэлэх, баримтжуулах боломжийг мөн олгох ёстой.

43. Нүүлгэн шилжүүлэлт нь хүнийг орон гэргүй болгох буюу хүний бусад эрхийг ямар нэг байдлаар зөрчих, эмзэг байдалд оруулах ёсгүй. Улс орнууд өөрт байгаа нөөц боломжийг шавхан дайчилж, шаардлагад нийцсэн орон байрны хувилбараа шийдвэрлэж чадахгүй байгаа, цаанаас нь олгосон эсвэл олж авах боломжтой үржил шимтэй газрыг авах, шилжин суурьшиж чадахгүй байгаа тэр хүмүүст тохирсон арга хэмжээг авах ёстой. Орон байрны хувилбарууд нь нүүлгэн шилжүүлэгдсэн хүмүүсийн өмнө нь амьдарч байсан газар болон амьжиргааны эх үүсвэртэй нь аль болохоор ойролцоо нөхцөлтэй байвал зохино.

44. Орон байр барьж байгуулах, ус, цахилгаан, ариун цэврийн байгууламж, сургууль, замаар хангах, газар хуваарилалт зэрэг

дахин суурьшуулах бүхий л арга хэмжээнүүд нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийн зарчмуудтай нийцсэн байх ёстой ба хүмүүсийг амьдарч байгаа газраас нь нүүлгэн шилжүүлэхээс өмнө хийгдсэн байх ёстой.

## **I. Нүүлгэн шилжүүлэлтийн үед**

45. Нүүлгэн шилжүүлэх бүсэд төрийн албан тушаалтан, эсвэл тэдний төлөөлөгчид заавал байлцаж, хүний эрхийг хамгаалах хэм хэмжээг хэрэгжүүлэх үйл явцын шаардлагыг баталгаажуулах ёстой. Нүүлгэн шилжүүлж байгаа төрийн албан тушаалтан, тэдний төлөөлөгчид нь нүүлгэгдэж байгаа иргэдэд өөрсдийн албан ёсны зөвшөөрлийг үзүүлж, эрх бүхий хүмүүс гэдгээ батлах ёстой.

46. Хүсэлт гаргасан тохиолдолд бүс нутгийн болон олон улсын ажиглагчид гэх мэт хөндлөнгийн ажиглагчдад аливаа нүүлгэн шилжүүлэлтийн ил тод байдал, хүний эрхийн зарчмуудтай хэр нийцэж байгааг ажиглах боломжийг олговол зохино.

47. Нүүлгэн шилжүүлэлт нь нөлөөлөлд өртсөн хүмүүсийн нэр төр, аюулгүй байдал, амьдрах эрхийг ямар нэг байдлаар зөрчсөн хэлбэрээр явагдах ёсгүй. Улс орнууд нүүлгэн шилжүүлэлтийн үед эмэгтэйчүүдийг алагчлах мөн жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөхгүй байх, хүүхдийн эрхийг хамгаалах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх ёстой.

48. Хууль сахиулагчдын хүч хэрэглэх болон галт зэвсэг хэрэглэхдээ баримтлах үндсэн зарчим зэрэг хуулийн дагуу хүч хэрэглэх аливаа асуудал нь үндэсний болон бүс нутгийн удирдлага болгох нэгдсэн дүрэм, олон улсын хууль дүрэм болон хүний эрхийн хэм хэмжээтэй нийцүүлэн хэрэгжүүлэх, хүч хэрэглэх зайлшгүй шаардлага ба хэр хэмжээндээ тохирсон байх зарчмыг хангасан байвал зохино.

49. Нүүлгэн шилжүүлэлтийг цаг агаар таагүй байхад, шөнийн цагаар, баяр наадам болон шашны амралтын өдрүүдээр, сонгуулийн өмнө, сургуулийн шалгалтын үед болон өмнө нь явуулахгүй байвал зохино.<sup>5</sup>

---

<sup>5</sup> Энэхүү удирдамжийн 5 дахь хэсгийг үзнэ үү.

50. Улс орнууд болон тэдний бие төлөөлөгчид эмх замбараагүй халдлага, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдийн эсрэг хүчирхийллийн ямар нэг хэрэг гарах, эвдлэн сүйтгэх, санаатай галдан шатаах болон бусад хэлбэрээр хорлон сүйтгэснээс болж эд хөрөнгө, эзэмшил газраа алдаж, үгүйрэн хоосрох, үл хайхрах болон хоморголон шийтгэх аливаа хэрэгт хэн ч шууд болон бусад хэлбэрээр хохирохгүй байх арга хэмжээг авах ёстой. Санамсаргүйгээр орхигдсон эд хөрөнгө, эзэмшил газрыг эвдлэн сүйтгэх, дур зоргоор болон хууль бусаар эзэмших, ашиглах, шамшигдуулахаас хамгаалах ёстой.

51. Албан тушаалтнууд болон тэдний бие төлөөлөгчид нүүлгэн шилжүүлэгдсэн хүмүүсийг өөрсдийн орон гэр болон бусад байгууламжаа устгахыг шаардах болон хүчлэх ёсгүй. Ийм сонголтыг зөвхөн нөлөөлөлд өртсөн хүмүүсийн эд хөрөнгө, барилгын материалыг аварч хамгаалахад туслах зорилгоор л хийж болно.

## **II. Нүүлгэн шилжүүлэлтийн дараа: Яаралтай тусламж ба шилжүүлэн байршуулах**

52. Засгийн газар, холбогдох талууд давагдашгүй хүчин зүйлээс бусад тохиолдолд нүүлгэн шилжүүлэлт явагдсан даруйд шударга нөхөн олговрыг олгох, орон сууцны хангалттай хувилбарууд болон боломжтой болонгуут анхны байдалд нь буцаан оруулах арга хэмжээ авах хариуцлагыг хүлээнэ. Нөхцөл байдлаас үл хамааран эрх бүхий албан байгууллагууд наад зах нь нүүлгэн шилжүүлэгдсэн хүмүүс болон бүлгүүд, ялангуяа өөрсдөө арга хэмжээ авч чадахгүй хүмүүсийг

- (а) хоол хүнс, ундны ус, ахуйн цэвэрлэгээ ариун цэврийн нөхцөл,
- (б) орогнох байр болон орон сууц,
- (в) шаардлагатай хувцас хунар, хоол хүнс
- (г) эмнэлгийн суурь үйлчилгээ,
- (д) амьжиргааны эх үүсвэр,
- (е) малын тэжээл болон өмнө нь амьжиргаагаа залгуулдаг байсан нийтийн эзэмшлийн нөөцөд нэвтрэх боломж,
- (ё) хүүхдүүдэд боловсрол олгох, хүүхэд харах боломжоор хангах ёстой.

Улс орнууд нүүлгэн шилжүүлэлтээс болж хамт амьдардаг байсан олон ам бүлтэй гэр бүл, айл сахалтын хүмүүсийг салгаж тусгаарлахгүй байхад анхаарна.

53. Эмэгтэйчүүдийг төлөвлөлтийн бүхий л үе шатанд тэгш оролцуулах, хангамжийн бараа материал, үйлчилгээ авах, тараахад тэгш оролцуулах боломжоор хангахын тулд онцгой хүчин чармайлт гаргах ёстой.

54. Бие махбодын болон сэтгэлзүйн эрүүл мэндтэй холбоотой хүний эрхийг байж болох хамгийн дээд хэмжээгээр хамгаалахын тулд нүүлгэн шилжүүлэгдсэн, өвчтэй болон гэмтэж бэртсэн хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст шаардлагатай эмнэлгийн халамж үйлчилгээг авч болох хамгийн дээд хэмжээнд, аль болох цаг алдалгүйгээр, эмнэлгийн бус үйлчилгээг ч ялгаваргүйгээр үзүүлэх ёстой. Шаардлагатай бол нүүлгэн шилжүүлэгдсэн хүмүүст нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлнэ. Үүнд

- (а) Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ, мөн бэлгийн болон бусад төрлийн хүчирхийллийн хохирогчдыг шаардлагатай зөвлөгөөгөөр хангах, эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжийг багтаасан хүүхэд, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг хэрэгцээг хангах,
- (б) Явагдаж байсан эмчилгээ нүүлгэн шилжүүлэлт болон дахин суурьшуулалтын үед тасалдахгүй байх,
- (в) Дахин суурьшуулалтын бүсэд ДОХ/ХДХВ зэрэг хүрэлцэхээр халдварладаг, эсвэл агаар дуслын замаар халдварладаг бусад халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэхэд онцгой анхаарал хандуулах ёстой.

55. Дахин суурьшуулалт хийгдэхээр тодорхойлогдсон газар нь хүний эрхийн олон улсын эрх зүйн дагуу шаардлагад нийцсэн орон байртай байх шаардлагатай нийцсэн байх ёстой. Эдгээр нь

- (а) эзэмшлийн аюулгүй байдал<sup>6</sup>
- (б) ундны ус, хоол хийх цахилгаан, халаалт болон гэрэлтүүлэг, ариун цэврийн байгууламж, хүнс хадгалах агуулах, хог хаягдал зайлуулах, ус сувгийн болон онцгой байдлын үед хэрэглэх талбай, хэрэв боломжтой бол байгалийн болон нийтийн эзэмшлийн нөөцийг ашиглах боломж, материал, барилга байгууламж, дэд бүтэц,
- (в) боломжийн үнэтэй орон сууц,

<sup>6</sup> Эдийн засаг, Нийгэм, Соёлын Эрхийн Хорооны Ерөнхий зөвлөмж №4 (1991 он). Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн талаар

(г) оршин суугчдыг хүйтэн, чийг, халуун, бороо, салхи болон эрүүл мэндэд халтай бусад аюул, барилгын хийцтэй холбоотой болон өвчин тарааж болох бусад аюулаас хамгаалсан, хангалттай зай талбай бүхий амьдарч болохуйц орон байраар хангаж, оршин суугчдын биет аюулгүй байдлыг хангах,  
(д) эмзэг бүлгийн хүмүүст хүртээмжтэй байх,  
(е) хот, хөдөөгийн хаана ч байсан ажил олж хийх сонголт, эрүүл мэндийн үйлчилгээ, сургууль, цэцэрлэг болон нийгмийн бусад үйлчилгээ авах боломжтой байх,  
(ё) соёлын хувьд тохиромжтой орон байраар хангуулах зэрэг багтана.

Орон байрны аюулгүй байдлыг хангахын тулд шаардлага хангасан байр нь хувийн амьдрал болон аюулгүй байдал, шийдвэр гаргахад оролцох, хүчирхийллээс ангид байх, болон бусад зовлон бэрхшээлийг гэтлэх боломжтой байх зэргийг мөн багтаадаг.

56. Улс орнууд энэ удирдамжийн дахин суурьшуулах үйл явцад хэр нийцтэй байгааг тодорхойлохдоо дахин суурьшуулах ямар ч тохиолдол дараах шаардлагуудыг баримтлахад анхаарна Үүнд:

(а) Энэхүү удирдамж болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийн зарчмуудад нийцсэн дахин суурьшуулалтын иж бүрэн бодлого бэлэн болох хүртэл ямар ч дахин суурьшуулалт хийгдэх ёсгүй.  
(б) Дахин суурьшуулалтын явцад эмэгтэйчүүд, хүүхдүүд, нутгийн уугуул иргэд болон бусад эмзэг бүлгийнхний эд хөрөнгөө эзэмших, нөөцийг ашиглах боломжтой байх эрхүүдийг ижил тэгш хамгаалах явдлыг баталгаажуулна.  
(в) Дахин суурьшуулалтыг санал болгосон, эсвэл явуулж буй этгээдээс суурьшуулалтын бүх зардал болон бусад холбогдох зардлыг хуулийн дагуу төлөхийг шаардана.  
(г) Нөлөөлөлд өртсөн хүн бүрийн эрх нь зөрчигдөж, хохирох ёсгүй. Амьдрах нөхцөлийг үргэлжлүүлэн сайжруулах явцад ч тэдний эрх зөрчигдөх ёсгүй. Энэ заалт нь албадан нүүлгэлтэд өртсөн хүмүүсийг дахин суурьшуулах явцад тухайн хүмүүсийг хүлээн авч байгаа орон нутгийнханд нэгэн адил үйлчилнэ.  
(д) Нөлөөлөлд өртсөн иргэд, бүлэг, орон нутгийнхан дахин суурьшуулалтын талаарх бүрэн мэдээллийг урьдчилан хүлээн авсан байхыг баталгаажуулах ёстой. Улс орнууд тухайн санал болгож буй газартаа эдийн засгийн боломж

бололцоог олгож, тав тухтай байлгах бусад бүхий л нэмэлт үйлчилгээгээр хангана.

(е) Ажилдаа ирж очих болон шаардлагатай суурь үйлчилгээ авахаар явахад шаардагдах цаг хугацаа болон зардал нь орлого багатай өрхүүдийн төсвөөс хэтэрсэн байх ёсгүй.

(ё) Дахин суурьшуулалтын бүс нь оршин суугчдын бие махбодь, сэтгэцийн эрүүл мэндийн байж болох хамгийн дээд хэмжээнд байж аюул учруулж болох бохирдолтой газар буюу бохирдлын эх үүсвэртэй ойр байж болохгүй.

(ж) Тухайн дахин суурьшуулалттай холбоотой төрийн бүх төсөл, төлөвлөгөө, тэдгээрийг хэрэгжүүлэх явцтай холбоотой мэдээлэл, мөн нүүлгэн шилжүүлэлтээс үлдсэн орон байр, газар орныг ямар зорилгоор, хэн ашиглахаар төлөвлөж байгаа талаар нөлөөлөлд өртсөн бүх хүнд хангалттай мэдээлэл өгөх ёстой. Үүнд нутгийн уугуул иргэд, угсаатны цөөнх, газаргүй хүмүүс болон эмэгтэйчүүд, хүүхдүүд хамрагдаж чадсан эсэхэд онцгой анхаарал тавих ёстой.

(з) Дахин суурьшуулалтын бүхий л явц нөлөөлөлд өртсөн бүхий л хүмүүсийн бүрэн оролцоотойгоор явагдах ёстой. Улс орнууд ялангуяа, нөлөөлөлд өртсөн хүмүүс, бүлэг, тухайн газрынхны санал болгосон бүхий л төлөвлөгөөний хувилбаруудыг анхааран авч үзэх ёстой.

(и) Хэрвээ бүх нийтийг хамарсан бүрэн дүүрэн хэлэлцүүлгийн дараа дахин суурьшуулалтыг явуулах нь зүйтэй гэсэн шийдвэр гарвал нөлөөлөлд нь өртөх хүн бүрт дахин суурьшуулалт явуулахаас дор хаяж 90 хоногийн өмнө мэдэгдэл өгсөн байх ёстой,

(й) Орон нутгийн төрийн албан хаагч, хараат бус ажиглагчид дахин суурьшуулалтын явцад байлцаж, ямар нэгэн хүч хэрэглэсэн, хүчирхийлэл болон айлган сүрдүүлэлт явагдсан эсэхэд хяналт тавина.

57. Дахин суурьшуулалтын бодлого нь эмэгтэйчүүд болон гадуурхагдсан, эмзэг бүлгийнхний орон сууц, хоол хүнс, ус, эрүүл мэнд, боловсрол, ажилтай байх, хувь хүний болон орон байрны аюулгүй байдал, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжилж харьцахаас ангид байх, чөлөөтэй зорчих эрхийг бусдын адил эдлэх боломжийг хангасан хөтөлбөрүүдийг багтаасан байна.

58. Нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүмүүс, бүлэг, орон нутгийнхны шаардлагад нийцсэн орон байртай байх эрхээ эдлэх бүхий л арга

хэмжээг оролцуулан эдлэх эрхэд нь ямар нэг байдлаар хор хохирол учрах ёсгүй. Энэ нь дахин суурьшуулалтын бүсэд хүмүүсийг хүлээн авч байгаа газар нутгийнханд мөн ижил үйлчилнэ.

### **III. Албадан нүүлгэн шилжүүлэлтийн үед авах хамгаалах арга хэмжээ**

59. Албадан нүүлгэн шилжүүлэлтийн үед айлган сүрдүүлэлт эсвэл ямар нэг хэлбэрээр хүчинд автсан хүмүүс хамгаалуулах арга хэмжээнд нэн даруй хамрагдах эрхтэй. Бодит хэлэлцүүлэг, хуулийн зөвлөгөө болон туслалцаа авах, гэм хороо арилгуулах, буцаан төлүүлэх, дахин суурьшуулах, хэвийн амьдралдаа эргэн орох, нөхөн олговор авах зэрэг нь Хүний эрхийн олон улсын эрх зүйн хэм хэмжээг бүдүүлгээр зөрчсөнөөс болон Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн хэм хэмжээг ноцтой зөрчсөнөөс болж хохирогсдын эрхийг хамгаалах, нөхөн төлбөр олгох Ерөнхий зарчим, удирдамжуудад нийцсэн зохистой хамгаалах арга хэмжээ байна.

#### **A. Нөхөн олговор**

60. Нүүлгэн шилжүүлэх нь гарцаагүй болсон тохиолдолд, Улс орнууд нийтийн сайн сайхны тусын тулд тухайн хувь иргэний эд хөрөнгийн ашиг сонирхлыг багтаасан үл хөдлөх болон бусад эд хөрөнгийн хохирлыг шударга нөхөн олговроор төлөхөө баталгаажуулах ёстой. Нөхөн олговор нь эд эрхтэн эсвэл амь насаа алдах, биеийн болон сэтгэлзүйн хохирол, ажлын байр, боловсрол болон нийгмийн хамгааллын тэтгэмж зэрэг алдагдсан боломжууд, цалин хөлс, түүн дотроо авч болох байсан хамгийн дээд цалин хөлсний алдагдал зэрэг материаллаг хохирол, эмчилгээ, эмнэлгийн үйлчилгээ, сэтгэл зүйн болон нийгмийн үйлчилгээ зэрэг хууль зүйн, эсвэл бусад төрлийн мэргэжилтнүүдийн туслалцааг авахад шаардлагатай хөлс зэргийг багтаасан мөнгөөр үнэлж болохуйц аливаа хохирлыг гарсан тохиолдолд бүрд, хохирлын хэр хэмжээнд аль болох зохистой хэмжээгээр тохирсон байдлаар олгогдох ёстой. Бэлэн мөнгөний нөхөн олговор нь газар болон нийтийн эзэмшлийн нөөц зэрэг жинхэнэ нөхөн олговрыг ямар ч нөхцөлд орлохгүй. Газрыг нь авсан бол нүүлгэн шилжүүлэгдсэн хүмүүст чанар, хэмжээ, үнэ цэнэд нь нийцсэн эсвэл илүү дээр газраар нөхөн төлнө.

61. Нүүлгэн шилжүүлэгдсэн бүх хүмүүс, тухайн эд хөрөнгөө



албан ёсоор өмчлөх эрхтэй байсан эсэхээс үл хамааран, амьдарч байсан орон сууц, газар нь нүүлгэн шилжүүлэлтийн явцад эвдэрч гэмтсэн эсвэл алга болох зэргээр нөлөөлөлд өртсөн эд хөрөнгөө тээвэрлэх, хамгаалах, мөн хохирлоо нөхөн төлүүлж авах эрхтэй. Нөхөн олговрыг олгохдоо бүхий л нөхцөл байдлыг харгалзан үзэх ёстой ба үүнд албан бус эд хөрөнгө, овоохой ч байсан багтана.

62. Эмэгтэй, эрэгтэй хүмүүс нөхөн олговрын багцыг ижил тэнцүү авах ёстой. Ганц бие болон бэлэвсэн эмэгтэйчүүд өөрийн нөхөн төлбөрийг авах эрхтэй.

63. Шилжүүлэн байршуулах үед ямар нэг байдлаар туслалцаа авч чадаагүй бол, эдэлбэр газар, байшингийн бүтэц, эд хогшил, дэд бүтэц, үл хөдлөх хөрөнгийн зээл болон өр төлөхтэй холбоотой бусад үүргүүд, түр орон сууц, хүнд суртал болон хуулийн үйлчилгээний хөлс, орон байрны хувилбарууд, цалин хөлс, боловсролын болон орлогын алдагдсан боломжууд, эрүүл мэнд болон эмнэлгийн үйлчилгээ, дахин суурьшуулалтын үеийн тээврийн зардал зэрэг эдийн засгийн алдагдалд үнэлгээ хийж, алдагдал болон зардлыг анхаарч үзэх ёстой (ялангуяа шилжүүлэн байршуулж буй газар нь амьжиргааны эх үүсвэрээс хол байгаа тохиолдолд). Гэр орон болон нүүлгэн шилжүүлэгдсэн оршин суугчдын амьжиргааны эх үүсвэр болсон газар, бизнесийн алдагдал, тоног төхөөрөмж, эд хөрөнгө, мал, газар, мод, болон алдагдсан болон багассан ашиг орлогын байдалд нөлөөллийн болон алдагдлын үнэлгээ хийнэ.

## **В. Гэм хорыг арилгах ба эргэн ирэх**

64. Албадан нүүлгэлт нь бүтээн байгуулалт болон дэд бүтцийн төслүүдтэй холбоотой бол гэм хорыг арилгах, эргэж буцах явдал ховор байдаг. (8 дугаар догол мөрөнд дурдагдсан) Гэсэн хэдий ч боломж гарангуут, Улс орнууд албадан нүүлгэлтэд өртсөн бүх хүн, бүлэг, газар нутгийнхны эрх ашгийг нэн тэргүүнд тавина. Өөрсдийн гэр орон, газар, өсч төрсөн нутагтаа буцах гэсэн хэний ч хүсэл зоригийг хүчээр хориглох ёсгүй.

65. Буцан ирэх гарцаагүй эсвэл энэхүү удирдамжинд тусгагдсан шаардлага хангагдаагүй үед дахин суурьшуулалт хийх бол, холбогдох эрх бүхий этгээд, байгууллага нь хүмүүсийг өөрийн төрсөн нутаг, орон гэртээ сайн дураараа, нэр төртэйгөөр, аюулгүй

эргэн ирэх санхүүгийн боломж нөхцөлөөр хангах зэрэг шаардлагатай бүх арга хэмжээг авна. Үүрэг хүлээсэн албан тушаалтнууд эргэж ирсэн хүмүүсийг суурьшуулах ажлыг удирдаж, нөлөөлөлд өртсөн хүмүүс, бүлэг, нийтлэгийн бүрэн оролцоог энэ үйл ажиллагааны төлөвлөлт, менежментийн үе шатуудад хангаж ажиллах ёстой. Эмэгтэйчүүдийг ялгаварлах, орхигдуулахад хүргэж байгаа, айл өрх, нийтлэгийн уламжлал, байгууллагын болон хууль зүйн бусад хэлбэрээр оршин байгаа жендэрийн ялгаатай ойлголтыг даван туулахын тулд эргэн суурьшуулах явцад эмэгтэйчүүдийн тэгш, үр нөлөөтэй оролцоог хангасан тусгай зохицуулалт шаардагдаж болно.

66. Эрх бүхий албан тушаалтнууд нүүлгэн шилжүүлэлтийн үеэр эд хөрөнгөө орхисон буюу хураалгасан хүмүүс, бүлэг, нийтлэгт эд хөрөнгө, эзэмшлийн зүйлээ эргүүлэн олж авах, эргэн төвхнөхөд нь туслалцаа үзүүлэх боломжтой бүхий л арга хэмжээг авах үүрэгтэй.

67. Хэн нэгэн амьдарч байсан орон байр, эд хөрөнгөө буцаан авах боломжгүй болсон тохиолдолд эрх бүхий албан тушаалтнууд албадан нүүлгэлтэд хохирсон иргэдэд эд хөрөнгөө буцаан олж авах, тохирсон хэмжээний нөхөн төлбөр олж авах, эсвэл шударга нөхөн төлбөрийн бусад хэлбэрээр туслалцаа үзүүлнэ.

### **C. Дахин суурьшуулалт ба хэвийн амьдралдаа эргэн орох**

68. Бүхий л оролцогч талууд эргэн ирэх эрхэд анхаарлаа хандуулах ёстойгоос гадна бүтээн байгуулалтаас үүдэлтэй нүүлгэн шилжүүлэлтээс хохирсон тодорхой хүмүүс, бүлэг, нийтлэгийн дахин суурьших асуудалтай холбоотой зарим нэгэн нөхцөл байдлуудыг (нийтийн сайн сайхан, аюулгүй байдал, хангах шаардлагатай эрүүл мэндийн болон хүний эрхийн асуудлууд) шийдвэрлэх шаардлагатай болж мэдэх юм. Тийм дахин суурьшуулалт нь шударга, тэгш байдалтайгаар, энэхүү удирдамжийн 5 дахь хэсэгт тусгагдсан хүний эрхийн олон улсын эрх зүйд бүрэн нийцсэн байдлаар явуулна.

### **IV. Хяналт, үнэлгээ болон эргэн хянах**

69. Улс орнууд өөрсдийн газар нутаг, шүүхийн харъяаллын дагуу явагдсан албадан нүүлгэн шилжүүлэлтийн тоо, хэлбэр, урт хугацаанд үүсэх нөхцөл байдлуудад тооны болон чанарын үнэлгээ хийж, хяналт шинжилгээг идэвхтэйгээр явуулна. Хяналт шинжилгээний тайлан,

үр дүн нь сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, асуудлыг шийдвэрлэх туршлагад суурилсан сургамжуудыг хуваалцах зорилгоор олон нийт болон хамаарал бүхий олон улсын оролцогч талуудад нээлттэй байна.

70. Улс орнууд албадан нүүлгэлтэд хяналт үнэлгээ хийх үүргийг үндэсний хүний эрхийн байгууллага гэх мэт үндэсний хараат бус байгууллагад хүлээлгэж, тухайн улс энэхүү удирдамж болон хүний эрхийн олон улсын эрх зүйд нийцсэн үйл ажиллагаа явуулсан эсэхийг шалгуулна.

## **V. Олон улсын байгууллага, хамтын нийгэмлэгийн хүлээх үүрэг**

71. Олон улсын хамтын нийгэмлэг хүний орон байр, газар, өмчтэй байх эрхийг хангаж, хамгаалах, хөхүүлэн дэмжих үүргийг хүлээдэг. Олон улсын санхүү, худалдаа, хөгжлийн болон бусад холбогдох байгууллагууд, агентлагууд, тэдгээрийн доторх саналын эрхтэй гишүүн болон хандивлагч орнууд албадан нүүлгэн шилжүүлэлтийн хориг нь хүний эрхийн олон улсын эрх зүй болон холбогдох хэм хэмжээнд нийцсэн эсэхийг бүрэн анхааралдаа авна.

72. Албадан нүүлгэлтийн хэргүүд нь тухайн байгууллагын өөрийнх нь тогтсон уламжлал, бодлогын үр дүн болохыг хүлээн зөвшөөрч олон улсын байгууллагуудад гомдол гаргах механизм бий болгох ёстой. Энэхүү удирдамжид зааснаар хязгаарлагдахгүй хохирсон хүмүүс хуулиар эрхээ сэргээлгэх боломжтой байна.

73. Үндэстэн дамнасан корпорациуд болон бизнесийн бусад байгууллага өөрийн үйл ажиллагааны хамрах хүрээ, нөлөөллийн дотор албадан нүүлгэхээс ангид байх хүний эрх болон шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хүндэтгэн үзнэ.

## **VI. ТАЙЛБАР**

74. Хөгжилд суурилсан нүүлгэлт болон шилжилт хөдөлгөөний талаарх үндсэн зарчим, удирдамжийг олон улсын хүний эрхийн эрх зүйн дагуу дүрвэгч, гэмт хэрэгтэн эсвэл хүмүүнлэгийн эрх зүй болон холбогдох хэм хэмжээ, аливаа дотоодын хуулийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөн хууль, дүрэм журмыг ямар нэг байдлаар хязгаарлах, өөрчлөх, гэм хор учруулах байдлаар тайлбарлах ёсгүй.

## **ХАВСРАЛТ**

### **ШААРДЛАГАД НИЙЦСЭН ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХИЙН ТАЛААРХ ЗАРИМ ОЛОН УЛСЫН БАРИМТ БИЧИГ (ОН ЦАГИЙН ДАРААЛЛААР)**

#### **Олон улсын гэрээ, конвенц**

НҮБ-ын Дүрэм (1945)

Дүрвэгчдийн эрх зүйн байдлын тухайн Конвенц (1951)

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт (1951)  
болон түүний Нэмэлт Протокол (2008)

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт (1966)  
болон түүний Нэмэлт Протоколууд (1966, 1999)

Арьс үндсээр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын  
Конвенц (1965)

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу  
хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенц  
(1984) болон түүний Нэмэлт Протокол (2002)

Тусгаар тогтносон улс орнууд дахь Уугуул иргэд болон омгийн  
хүмүүсийн эрхийг хамгаалах тухай ОУХБ-ын 169 дүгээр Конвенц  
(1989)

Хүүхдийн Эрхийн тухай Конвенц (1989) болон түүний нэмэлт хоёр  
Протокол (2000)

Цагаач ажилчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрхийг  
хамгаалах тухай олон улсын Конвенц (1990)

Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц (1979)  
болон түүний нэмэлт Протокол (1999)

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенц (2006)  
болон түүний Нэмэлт Протокол (2006)

#### **Бүс нутгийн гэрээ, конвенц**

Хүний болон ард түмний эрхийн талаарх Африкийн Харти (1981)

Хүүхдийн эрх, нийгмийн хамгааллын талаарх Африкийн Харти  
(1990)

Хүний эрх болон үндсэн эрх чөлөөг хамгаалах Европын Конвенц  
(1950)

Европын Нийгмийн Харти (1961)

Цагаач ажилчдын эрх зүйн байдлын талаарх Европын Конвенц (1977)

Европын Нийгмийн Хартийн шинэчлэсэн найруулга (1996)  
Хүний эрхийн Америкийн конвенц (1969)

## **Олон улсын тунхаглал болон бусад баримт бичиг**

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал (1948)  
Ахмад настны талаар баримтлах НҮБ-ын Зарчмууд, Ерөнхий  
Ассамблейн тогтоол 47/91 (1991)  
Дотоодын шилжилт хөдөлгөөний талаар баримтлах зарчмууд (1998)  
Ажилчдын орон байрны талаарх ОУХБ-ын 115 тоот зөвлөмж (1961)  
Уугуул иргэдийн эрхийн талаарх НҮБ-ын Тунхаглал, Ерөнхий  
Ассамблейн тогтоол 61/295 (2007)

## **Хүний эрхийн байгууллагын шинжээчдийн боловсруулсан удирдамж**

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хороо, Ерөнхий Зөвлөмж  
№3 (1990) Оролцогч улсуудын хүлээх үүргийн мөн чанарын талаар  
(E/1991/23)  
Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хороо, Ерөнхий Зөвлөмж  
№4 (1991) Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн талаар  
(E/1992/23)  
Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хороо, Ерөнхий Зөвлөмж №5  
(1994) Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар (E/1995/22)  
Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хороо, Ерөнхий Зөвлөмж  
№7 (1997) Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх: Албадан  
нүүлгэлт (E/1998/22, хавсралт IV)  
Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хороо, Ерөнхий Зөвлөмж №15  
(2002) Цэвэр усаар хангагдах эрх (E/C.12/2002/11)  
Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах Хороо, Ерөнхий  
Зөвлөмж №19 (1992) Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар  
(A/47/38)  
Арьс үндсээр алагчлах бүх хэлбэрийг устгах Хороо, Ерөнхий  
Зөвлөмж №23 (1997) Уугуул иргэдийн эрхийн талаар (A/52/18,  
хавсралт V)  
Дүрвэгсэд болон шилжин суурьшигчдын орон байр болон эд  
хөрөнгийг нөхөн сэргээх талаар баримтлах зарчим (E/CN.4/  
Sub.2/2005/17/Add.1)  
Хөгжилд суурилсан нүүлгэлт болон шилжилт хөдөлгөөний талаар  
баримтлах Үндсэн зарчим, удирдамж (A/HRC/4/18, хавсралт I)

## **Хүний Эрхийн Хороо болон Хүний Эрхийн Зөвлөлийн тогтоол**

Амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрхийн бүрэлдэхүүн хэсэг болох шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн талаарх Хорооны 2000/9, 2001/28, 2002/21, 2003/27, 2004/21 тоот тогтоолууд

Албадан нүүлгэн шилжүүлэлтийн талаарх Хорооны 1993/77 тоот тогтоол Газар олж авах, түүнийг эрхлэн удирдах харилцаанд эмэгтэйчүүд эрх тэгш байдлаар өмчлөх эрхээ эдлэх, өөрийн хөрөнгө, шаардлагад нийцсэн орон байртай байх эрхээ тэгш байдлаар хэрэгжүүлэх эрхийн талаарх Хорооны 2000/13, 2001/34, 2002/49, 2003/22, 2004/21, 2005/25 тоот тогтоолууд

Амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрхийн бүрэлдэхүүн хэсэг болох шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн талаарх Зөвлөлийн 6/27 тоот тогтоол

## **Олон улсын хурлаас гаргасан баримт бичиг**

Хүм амын суурьшлын талаарх Истанбулын Тунхаглал (1996)

Хабитат Хөтөлбөр (1996)

НҮБ-ын Ерөнхий Ассамблей буюу “НҮБ-ын Мянганы Ассамблей”-н баталсан НҮБ-ын Мянганы Тунхаглал (2000)

Хүн амын суурьшлын талаарх Ванкувэрийн Тунхаглал (1976)

НҮБ-ын Хүрээлэн буй орчин ба хөгжлийн асуудлаар болсон бага хурлаас гаргасан Хүрээлэн буй орчин ба Хөгжлийн талаарх Риогийн Тунхаглал ба Хорин нэгдүгээр зууны мөрийн хөтөлбөр (1992)

Хүний эрхийн дэлхийн бага хурлаас баталсан Вэнийн Тунхаглал ба Үйл ажиллагааны хөтөлбөр (1993)

## **Цахим сайт**

### **Засгийн газар хоорондын байгууллагууд**

НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газар: [http:// www.ohchr.org](http://www.ohchr.org) (Энэхүү цахим сайт нь эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн талаарх ерөнхий мэдээлэл, эх сурвалжаас гадна хүний эрхийн олон улсын гэрээний байгууллагууд, амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрхийн бүрэлдэхүүн хэсэг болох шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгчийн цахим хуудас гэх зэрэг тусгай журмын цахим хуудсуудтай.)

НҮБ-ын Хүм амын суурьшлын Хөтөлбөр (НҮБ-Хабитат): <http://www.unhabitat.org>

НҮБ-ын Орон байртай байх эрхийн талаарх Хөтөлбөр <http://www.unhabitat.org/unhrp>

НҮБ-Хабитатын Гүйцэтгэх захиралд тайлагнах үүрэгтэй Албадан нүүлгэн шилжүүлэлтийн талаарх Зөвлөлдөх Бүлэг (AGFE): <http://www.unhabitat.org/unhrp>

Хотын ядуу иргэдэд зориулсан орон сууц (НҮБ-ын Эдийн засаг болон Нийгмийн Хорооноос Ази, Номхон далайн улс орнуудад хэрэгжүүлсэн төсөл): <http://www.housing-the-urban-poor.net>

Европын Зөвлөлийн Хүний эрхийн асуудал хариуцсан комиссар: <http://www.coe.int/t/commissioner>

## **Олон улсын төрийн бус байгууллагууд**

Эмнести Интернэшнл: <http://www.amnesty.org>

Орон байрны эрхийн талаарх Азийн Эвсэл (ACHR): <http://www.achr.net>

Орон байрны эрх болон нүүлгэн шилжүүлэлтийн Төв (COHRE): <http://www.cohre.org>

Орон гэргүй хүмүүстэй ажилладаг Үндэсний байгууллагуудын

Европын Холбоо (FEANTSA): <http://www.feantsa.org>

Европын Цыган иргэдийн эрхийг хамгаалах төв (ERRC): <http://www.errc.org>

Хүнснийг нэгдүгээрт: мэдээлэл болон үйл ажиллагааны Сүлжээ (FIAN): <http://www.fian.org>

Хабитат Олон улсын Эвсэл (HIC): <http://www.hic-net.org>

Хөүмлөс Интернэшнл: <http://www.homeless-international.org>

Орон байр болон газрын эрхийн Сүлжээ (HLRN): <http://www.hlrn.org/english/home.asp>

Хүний эрхийн хяналт (Human rights watch-HRW): <http://www.hrw.org>

Олон улсын хуульчдын Комисс (ICJ): <http://www.icj.org>

Хүний Эрхийн Олон улсын Холбоо (FIDH): <http://www.fidh.org>

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын Сүлжээ (ESCRNet): <http://www.escr-net.org>

Түрээслэгчийн эрхийг хамгаалах олон улсын Холбоо (IUT): <http://www.iut.nu>

Слам Двэллэрс Интернэшнл (Slum Dwellers International-SDI): [www.sdinet.org](http://www.sdinet.org)

Нийгмийн хяналт: <http://www.socialwatch.org>

Эрүүдэн шүүхийн эсрэг Дэлхийн байгууллага (OMCT): <http://www.omct.org>

## Хүний Эрхийн Мэргэжлийн гарын авлага:<sup>1</sup>

- № 2 Хүний эрхийн олон улсын Билл (Товхимол 1)
- № 3 Хүний эрхийн салбарын Зөвлөх үйлчилгээ болон Техникийн Хамтын Ажиллагаа (Товхимол 1)
- № 4 Эрүүдэн шүүхтэй тэмцэх нь (Товхимол 1)
- № 6 Хүчээр эсхүл сайн дурын бус үндсэн дээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах нь (Товхимол 3)
- № 7 Гомдол гаргах журам (Товхимол 1)
- № 9 Уугуул иргэдийн эрх (Товхимол 1)
- № 10 Хүүхдийн эрх (Товхимол 1)
- № 11 Шүүхээс гадуур, хууль бусаар цаазын ялыг хэрэглэх нь (Товхимол 1)
- № 12 Арьс үндсээр алагчлахыг устгах Хороо
- № 13 Олон улсын Хүмүүнлэгийн эрх зүй ба Хүний эрх
- № 14 Орчин үеийн боолчлолын хэлбэрүүд
- № 15 Иргэний болон улс төрийн эрх: Хүний Эрхийн Хороо (Товхимол 1)
- № 16 Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хороо (Товхимол 1)
- № 17 Эрүүдэн шүүхийн эсрэг Хороо
- № 18 Цөөнхийн эрх (Товхимол 1)
- № 19 Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах Үндэсний Байгууллагууд
- № 20 Дүрвэгсэд ба хүний эрх
- № 21 Шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрх (Товхимол 1)
- № 22 Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах нь: Конвенц болон Хороо
- № 23 Эмэгтэйчүүд, хүүхдүүдийн эрүүл мэндэд хор хөнөөлтэй уламжлалт дадал заншлууд
- № 24 Цагаач ажилчдын талаарх олон улсын Конвенц ба түүний Хороо (Товхимол 1)
- № 25 Албадан нүүлгэлт ба Хүний эрх
- № 26 Дур зоргоор хорихтой тэмцэх Ажлын Хэсэг
- № 27 НҮБ-ын Тусгай илтгэгчдийн талаарх 17 түгээмэл асуулт

---

<sup>1</sup> Мэргэжлийн гарын авлага 1, 5, 8-ыг ашиглах боломжгүй. Бусад мэргэжлийн гарын авлагыг <http://www.ohchr.org> сайтаас харах боломжтой.



- № 28 Бизнесийн хэт ашгийн төлөөх үйл ажиллагаа нь өөрийгөө тодорхойлох хүний эрхэд нөлөөлөх нь
- № 29 Хүний эрхийг хамгаалагчид: Хүний эрхийг хамгаалагчдын эрхийг хамгаалах нь
- № 30 НҮБ-ын хүний эрхийн олон улсын гэрээний байгууллагуудын тогтолцоо - Хүний эрхийн тулгуур баримт бичиг болон олон улсын гэрээний байгууллагуудын танилцуулга
- № 31 Эрүүл мэндээ хамгаалах эрх
- № 32 Хүний эрх, Терроризм, Терроризмтой тэмцэх нь
- № 33 Эдийн засаг, нийгэм, соёлын эрхтэй холбоотой түгээмэл асуултууд

*Хүний эрхийн асуудлаар* цуврал болгон хэвлэдэг *мэргэжлийн гарын авлагыг* Женев хотод байрлах НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын газраас эрхлэн гаргадаг. Уг цувралд чухалчлан авч үзэх шаардлагатай хүний эрхийн болон тусгай ашиг сонирхолтой холбоотой асуудлуудыг түүвэрлэн тухайлсан байдлаар авч үздэг.

*Хүний Эрхийн асуудлаарх Мэргэжлийн гарын авлага* нь уншигчдын хүний эрхийн талаарх үндсэн ойлголт, НҮБ-аас хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих зорилгоор ямар үйл ажиллагаа явуулж байгаа, хүний эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломжтой олон улсын механизмыг хэрхэн ашиглах зэрэг ойлголтыг өгдөг. *Хүний Эрхийн асуудлаарх Мэргэжлийн гарын авлагыг* дэлхийн өнцөг булан бүрт үнэ төлбөргүй түгээдэг. Уг баримтын агуулгад ямар нэг өөрчлөлт оруулахгүй байх нөхцөлтэйгөөр НҮБ-ын албан ёсны хэлнээс бусад хэл рүү хөрвүүлэн хэвлэхийг зөвшөөрөх бөгөөд Женев хотод байрлах НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газарт мэдэгдэж, тухайн баримтын эх үүсвэр нь тус байгууллага болохыг заавал тэмдэглэсэн байна.



Х ү н и й Э р х